

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-4

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 4-34

---

*1.Монголбанкны 2022 оны үйл ажиллагааны тайлан,  
Монголбанкны Хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэх* 4-20

*2.Даатгалын салбарын эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл  
байдлын талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл  
сонсох* 20-34

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
06 дугаар сарын 20-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жавхлан, М.Оюунчимэг, Т.Энхтүвшин;  
Чөлөөтэй: Ч.Хүрэлбаатар, Б.Энхбаяр;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Ц.Цэрэнпунцаг.

**Нэг.Монголбанкны 2022 оны үйл ажиллагааны тайлан, Монголбанкны Хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэх**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч Г.Дөлгөөн, мөн банкны дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван, Хяналтын зөвлөлийн дарга Д.Даваасамбуу, Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, Санхүү, бүртгэлийн газрын захирал Ц.Гарьд, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал О.Одгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны зөвлөх Б.Нандингэрэл нар байлцав.

Монголбанкны 2022 оны үйл ажиллагааны тайлан, Монголбанкны Хяналтын зөвлөлийн тайланг Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч Г.Дөлгөөн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Н.Ганибал, О.Цогтгэрэл, Т.Доржханд нарын тавьсан асуултад Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч Г.Дөлгөөн, мөн банкны дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван, Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Хяналтын зөвлөлийн дарга Д.Даваасамбуу, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа нар хариулж, тайлбар хийв.

Монголбанкны 2022 оны үйл ажиллагааны тайлан, Монголбанкны Хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэв.

*Уг асуудлыг 12 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Даатгалын салбарын эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, мөн хорооны гишүүн Н.Хүдэрчулуун, ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Даатгалын газрын дарга З.Батболд, мөн газрын ахлах референт Н.Батцэцэг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Л.Сонор, мөн хэлтсийн зөвлөх Б.Жавхланцогт, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн захирал Б.Жавхлан, Бизнес хөгжил төслийн газрын дарга Б.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны зөвлөх Б.Нандингэрэл, референт Г.Чингүүнжав нар байлцав.

Даатгалын салбарын эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Л.Сонор, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Т.Доржханд нарын тавьсан асуултад Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, мөн хорооны гишүүн Н.Хүдэрчулуун, ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Бизнес хөгжил төслийн газрын дарга Б.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут 12 цаг 13 минутаас 13 цаг 05 минут хүртэл хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүд Даатгалын салбарын эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагуудын талаарх Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Л.Сонор, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нарын мэдээллийг сонслоо.

*Уг асуудлыг 13 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 54 минут үргэлжилж, 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 13 цаг 09 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
11 цаг 15 минут.

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ингээд хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Дамбын Батлут гишүүн ирсэн. Баагаагийн Баттөмөр гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Наянтайн Ганибал гишүүн ирсэн. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн. Тогмидын Доржханд гишүүн ирсэн. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн ирсэн. Чинбатын Ундрам гишүүн ирсэн. Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн. Содномын Чинзориг гишүүн ирсэн. Ингээд Байнгын хорооны ирц бүрдэж байгаа тул 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн байнгын хорооны Эдийн засгийн байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал хоёр асуудал байгаа.

1.Монголбанкны 2022 оны жилийн тайлан болон Хяналтын зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх.

2.Даатгалын салбар эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдлын талаарх холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсох гэсэн ийм хоёр асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орё.

### Монгол Банкны 2022 оны жилийн тайланг хэлэлцэж эхэлье.

Эдийн засгийн Байнгын хорооны хуралд оролц оролцож байгаа ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Дөлгөөн, Монголбанкны дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга Д.Даваасамбуу, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Монголбанкны Санхүү, бүртгэлийн газрын захирал Ц.Гарьд, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал О.Одгэрэл гэсэн хүмүүс ирсэн байна.

Танилцуулгатай холбоотой, танилцуулгыг Монголбанкны дэд Ерөнхийлөгч Г.Дөлгөөн хийе. Дөлгөөн захирлын микрофоныг нээе. Хэддүгээр микрофон ажлын хэсэг 1.

**Г.Дөлгөөн:** Эдийн засгийн Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж байна.

Монгол Улсын хувьд 2022 он томоохон сорилтуудтай үргэлжлэн тулсан жил байлаа. Монголбанкны бодлого үйл ажиллагаа, цар тахал, олон улсад бий болсон геополитикийн туйлын тогтворгүй байдлаас үүдэлтэй сөрөг нөлөөг зөөлрүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, инфляцыг хязгаарлах, банк санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэж ажиллалаа.

Өнгөрсөн онд манай улсын худалдааны гол түнш болох Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “ТЭГ КОВИД” бодлого хэрэгжүүлж ОХУ-ын Украйны зөрчилдөөнөөс үүдэн олон улсын харилцаа муудсан амаргүй жил болж өнгөрлөө.

Бүс нутагт үүссэн геополитикийн хямрал, үүнээс үүдэлтэй нийлүүлэлтийн гинжин сүлжээний доголдол дэлхийн нийтээр үнийн өсөлтийг эрчимжүүлж,

ялангуяа эрчим хүч, хүнсний үнийг өдөөж хөгжсөн, хөгжиж буй олон орнууд сүүлийн хэдэн 10 жил байгаагүй өндөр инфляцтай нүүр тулсан нь төв банкнуудын эдийн засгийн өсөлт, эсвэл инфляц гэсэн хүндхэн сонголттой тулгарсныг энд онцлон дурдмаар байна.

Дэлхийн тэргүүлэгч эдийн засагтай гүрнүүд болох Америкийн нэгдсэн улс Европын холбооны орнууд одоо ч өндөр инфляцтай, эдийн засгийн өсөлтийн сааралтай хэвээр байгааг нь дурдмаар байна.

Гадаад зах зээлд түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдсан нь манай экспортын орлогод эерэг нөлөө үзүүлсэн хэдий ч биет хэмжээгээр бүрэн сэргэж чадаагүйгээс уул уурхайн салбар 2022 онд уналттай гарлаа.

Гэхдээ бодит эдийн засгийн нийт дүнгээр 4.8 хувиар тэлсэн нь уул уурхайн бус салбарын сэргэлт, тодорхой хэлбэл Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлсэн зээл санхүүжилтийн багц бодлого, томоохон төслүүдийг эрчимжүүлсэн арга хэмжээний үр дүн юм.

Ийнхүү хөдөлмөр ихээр шингээдэг худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуй боловсруулах салбаруудын өсөлт жигд хүртээмжтэй байснаар Монгол Улсын эдийн засаг цар тахлын өмнөх үеийн түвшнийг давснаар сэргэлтийн төлөвлөлтөө ороод байна.

Дэлхий нийтээр бий болсон үнийн өсөлтийн шуурга манай улсад хүчтэй нөлөө үргэлжлүүлсээр. 2022 оны турш инфляцын талаас илүү хувийг зөвхөн импортын барааны үнийн өсөлтийг шууд нөлөө бүрдүүлсэн нь дотоодын үйлдвэрлэл дутмаг, импортоос өндөр хамааралтай хэрэглээний бүтэцтэй манай улсын хувьд нийлүүлэлтийн тогтвортой бөгөөд хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх нь инфляцын хязгаарлахад туйлын ач холбогдолтой болохыг нотлон харууллаа.

Мөн хоёр хөрш орны хувьд тээврийн гацаа, доголдол үүсэн манай улсын тээврийн хугацаа, зардлыг огцом нэмэгдүүлж, инфляцыг өдөөх, эдийн засгийн өсөлтийг удаашируулах зэрэг олон сөрөг нөлөөг дагуулсан юм.

Нүүрсний экспорт 2022 оны сүүлийн хагаст эрчимжсэн хэдий ч гадаад орны таагүй нөхцөл хилийн хязгаарлалт өнгөрсөн оны эхний хагаст эдийн засагт сөргөөр нөлөөлж байсныг та бүхэн санаж байгаа. Үүний зэрэгцээ гадаад бодлого гадаад болон дотоодын шатахууны үнийн өсөлт эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор импорт сүүлийн 2 жил дараалан огцом өссөнөөр төлбөрийн тэнцэл жилийн дүнгээр 727 сая ам долларын алдагдалтай гарч, улмаар гадаад валютын урсгалын нөөц маань 967 сая ам.доллараар буурлаа.

Ийнхүү өнгөрсөн онд гадаад тэнцвэр алдагдаж, нөөцийн хүрэлцээт байдал огцом буурсан тул хани харьцангуй уян хатан валютын нөөцийг хамгаалахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэхээс өөр сонголт Монголбанканд байгаагүй юм. Банк санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд Монголбанкны үйл аж ажиллагаа чиглэж байна. Монголбанкнаас санаачлан хэрэгжүүлж буй банкны салбарын шинэчлэлийн хөтөлбөр банкны салбарын эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд 2022 онд зарим банкнууд олон нийтэд нээлттэй хувьцаат компаниар арилжиж хувьцаат компанийн өмчлөлийн хэлбэрт шилжин эхэлсэн нь банкны салбарт том дэвшил боллоо.

Мөн төлбөрийн системийг шинэ шатад гаргаж токен үйлчилгээний систем нэвтрүүлэх дотоодын төгрөгийн ти картаар худалдааны түни орнуудад төлбөр тооцоо гүйцэтгэх боломжийг бүрдүүллээ. Цар тахал, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдал нь Монгол Улсын тогтвортой эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдөг эмзэг

байдлыг маш тодоор харууллаа. Тухайлбал гадаад үнээс дотоод үнэ ханих хүчтэй хамаарч тээвэр ложистикийн тогтвортой байдал нь бизнесийн тогтвортой байдалд маш хүчтэй нөлөөлж байна. Эдийн засгийн өсөлтийн хүртээмжийн асуудал нь цаашид эдийн засаг, нийгмийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой болохыг харууллаа.

Эдгээр улсуудын эдгээр асуудлууд нь мөнгөний бодлогын хэрэгслээр дангаар нь шийдвэрлэгдэх бололцоогүй тул Засгийн газартай энэ талаар чиглэлээр хамтран ажиллалаа.

Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Мөнгөний бодлогын хороо үнийн өсөлтийг хязгаарлаж, төгрөгийн ханишийг хамгаалах зорилгоор өнгөрсөн онд шаардлагатай бодлогын тохируулгуудыг цаг алдалгүй авч хэрэгжүүлсэн. Тухайлбал 2022 онд 5 удаагийн шийдвэрээр бодлогын хүүг нийтдээ 7 нэгж хувиар нэмэгдүүлсэн. Ингэхдээ эдийн засгийн сэргэлтийг удаашируулахгүй байхад онцгой анхаарч, зээлийн өсөлт 2022 онд дунджаар 19 хувьд хүрсэн. Монголбанкнаас үнийн өсөлтийн эсрэг авч хэрэгжүүлсэн бодлогын шийдвэрүүдийн үр дүнгээ өгч, 2022 оны 6 дугаар сард 16.9 хувьд хүрээд байсан инфляц оны эцэст 13.2 хувь болж саарсан төдийгүй энэ онд ч инфляц үргэлжлүүлэн буурах суурь нөхцөл болсоор байна.

Гэхдээ гадаад орчны тодорхой бус байдал нийлүүлэлтийн гаралтай болзошгүй шокууд, төсвийн тэлсэн бодлого зэрэг нь мөнгөний бодлогын үүсээд байсан орон зайг хязгаарлаж инфляц өндөр түвшинд хадгалагдах эрсдэл бий болгож байгааг онцолмоор байна.

Цаашид үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангахад

макро эдийн засгийн бодлогуудыг чиглүүлэх нь чухал болж байгаа бөгөөд Монголбанкны бодлого, үйл ажиллагаа инфляцыг зорилтот түвшинд эргүүлэн тогтворжуулах замаар эдийн засагт эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах, тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэж байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Танилцуулгатай холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Цогтгэрэл гишүүнийг тасалъя.

Б.Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн инфляц 22 онд 13.2 хувь байсан. Энэ бол мэдэхгүй дэлхийд ийм инфляцтай улсууд хэр зэрэг байдгийг мэдэхгүй. Маш том үзүүлэлт. Энэний нэг нь бол тодорхой хэсэг нь бол Монголбанкны үйл ажиллагаатай холбоотой. Нийлүүлэлтийнх нь өөр байлаа гэхэд эрэлтийн шинж чанартай инфляцууд бол байгаа. Миний ойлгож байгаагаар 50, 50 хувь байгаа байх гэж ингэж бодож байна.

Тэгээд бодлогын хүүгээ өсгөөд байгаа өнөөдөр чинь 13 хувь байж байгаа шүү дээ. 13 Хувийн бодлогын хүүтэй байхад бол арилжааны банкнаас зээл аваад бизнес хийнэ гэдэг юм байхгүй шүү дээ. 13 хувийн инфляцтай, 13 хувийн бодлогын хүүтэй байхад Монголд бизнес явна гэж байхгүй. Ийм л эдийн засагтай ийм орчинд л бид нар амьдарч байгаа юм. Тэгээд хэд хэдэн асуултууд байна.

Нэгдүгээрт нь Монгол Улс хар жагсаалтад ороод, нөгөө юу билээ өргөтгөсөн хяналттай улсуудын жагсаалтад явж байгаа. Одоо бидэнд чинь тэр хар өргөтгөсөн хяналтаасаа гараад эерэг үзүүлэлттэй орны тоонд орно гээд л яваад байгаа. Энэ ажил

маань ямар, ямар түвшинд, ямар юу хийгдэж байна гэсэн асуулт байна.

Хоёрдугаарт нь тэр Виржиний арлууд нөгөө Америкийн Вен билүү тэндээс баахан мөнгө хураасан л гээд байгаа шүү дээ. Тийм ээ. Тэрний гарал үүслийг тодорхойлсон уу. Хоёр дахь асуулт энэ.

Гурав дахь асуулт юу гэхээр энэ гадаад худалдаа ашигтай гараад байгаа юм. Энэ чинь 3.8 ч билүү дээ тэрбум долларын ашигтай гарч байгаа шүү дээ. Гэтэл төлбөрийн тэнцэл гэдэг үзүүлэлт нь 726, тэгээд санхүүгийн дансны алдагдлаараа нөхөөд ийм болчихсон байгаа юм. Тэгээд энэ чинь тэр гадагшаа гарч байгаа мөнгө маань ийм ашигтай байгаад байгаа мөртөө тэр мөнгө маань Монголд орж ирэхгүй байгаад байна. Энэ дээр Монголбанк ер нь юу гэж дүгнэлт хийж байгаа юм.

Дараагийн асуулт юу гэхээр энэ ипотекийн зээлтэй холбоотой асуудал. Ипотекийн зээл бол энэ санхүүгийн зах зээл энэ эдийн засгийн маш чухал нэг салбар нь мөн л дөө. Энэ бол эрэлт бол маш их байгаа. Харамсалтай нь бид нар энийг сайн зохицуулж чадахгүй 8 хувь гэж байснаа, 6 хувь болоод олдоц их муу байгаад байдаг. Энд ямар шүүмжлэл байдаг вэ гэхээр эдийн засагт тодорхой хуримтлал бий болгохгүй, эх үүсвэрийг нь олохгүйгээр Монголбанкаар мөнгө хэвлүүлээд тараачихсан гээд байдаг. Та нар энэ дээр энэ миний ойлгож байгаагаар бол өнгөрсөн жил мөнгөний бодлого ярихад энэ 23 оны эхний хагас жилд багтаагаад Засгийн газарт шилжүүлнэ гэсэн. Одоо ингээд эхний хагас дуусах чинь үндсэндээ хэдхэн хоног үлдэж байна шүү дээ. Арваадхан хоног үлдэж байна. Энэ хугацаанд энэ 7 сарын 1-нийхээ дотор Засгийн газар энийг шилжүүлж өгч чадаж байгаа юу.

Ер нь бол энэ ипотекийн зээл дээр цаашидаа та нар бас хэдэн жил хариуцаж ажилласны хувьд ямар сургамж авч байна, яаж ажиллах юм. Энэ бол үнэхээр

чухал ач холбогдолтой. Ард иргэдийн хувьд бол. Асар их хэмжээний орон сууц баригдаж байгаа. Одоо хүмүүс чинь мөнгө алга байна. Ипотекийн зээлээр энийг авах шаардлага байдаг. Тийм учраас энэ дээр ямар сургамж авч байна, ямар юм цаашидаа хийж ажиллах шаардлага байна. Энэ манай инфляц, энэ ханишид бол нөлөөлж байгаа юм чинь бас энэ ипотекийн зээл шүү дээ. Үнэхээр мөнгө хэвлээд тараачихсан юм бол нөлөөлж байгаа шүү дээ. Энийг та нар юу гэж үзэж байгаа вэ. Энэ манай энэ хямралын нөлөө чинь бол 23 онд яах бэ буурах боловч 25 он хүртэл үргэлжилнэ гэж байгаа шүү дээ. Тийм учраас энэ энэ тэртэй уялдуул.../минут дуусав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ. 2 номер, 2 номерын микрофон.

**Г.Долгөөн:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээр асуултын хувьд Монгол Улс 2020 оны 10 дугаар сард олон улсын мөнгө угаах терроризмтой тэмцэх байгууллагын бид бүгдийн ярьж занисанаар ФАТФ байгууллагын үүрэгт мөнгө угаах терроризмтой тэмцэх стратегийн дутагдалтай орны жагсаалтаас 2020 оны 10 дугаар сард гарсан байгаад байгаа. Яг одоогийн байдлаар Монгол Улс олон улсын энэ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллагын ямар нэгэн жагсаалтууд байхгүй. Гишүүн орнууд тэгэхдээ бүгдээрээ тодорхой хэмжээний үйл ажиллагаагаа хугацааны давтамжтайгаар тайлагнаад явдаг.

Манай улсын хувьд өнгөрсөн жилийн 7 дугаар сард Ази-Номхон далайн бүлэгт тайлангаа хүргүүлсэн байгаад байгаа. Тайланг хүргүүлснээр Монгол Улс техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн 39-ийг бүгдийг хангаж ажиллаж байгаа. Улсын Их Хурлаар хэлэлцэгдэхээр ашигийн бус байгууллагын тухай хууль хүлээгдэж байгаа. Энэ хууль эцэслэн батлагдаж хууль, эрх зүйн орчин тодорхой болсноор Монгол Улс энэ техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийг бүгдийг хангана.



Яг одоогийн байдлаар ямар нэгэн тийм өргөтгөсөн болон ямар нэгэн тийм тусгайлсан хяналт болон жагсаалтууд байхгүй. Ердийн горимоор дэлхийн бусад орнуудтай ижил түвшинд байгаа.

Хоёр дахь асуултын хувьд Виржиний арлаас хураагдсан мөнгө болон бусад олон улсын бид бүгдийн ярьж заншсанаар оффшор бүс болон бусад гадаад орноос хууль бусаар гарсан байж болзошгүй байгаа мөнгөн хөрөнгүүдийг татан төвлөрүүлэх ажлыг Засгийн газар хууль хяналтын байгууллагууд хамтраад хэрэгжүүлж байгаа. Яг бид бүгдэд байгаа мэдээллээр энэ мөнгийг Авлигатай тэмцэх газар хурааж аваад Монгол Улсын Улсын төсөв дээр Улсын төсвийн Төрийн сангийн дансанд төвлөрүүлдэг гэж ойлгож байгаа. Мөнгөний гарал үүслийн хувьд энэ мөнгийг хууль хяналтын байгууллага тухай бүрдээ мөрдөн байцаах болон үйл ажиллагаа явуулсны үндсэн дээрээс тогтоодог. Монголбанк энэ дээр бодлого, арга зүйн хувьд дэмжлэг үзүүлээд хамтран ажиллаад явж байгаа.

Монголбанкнаас тодорхой хэмжээний улсын байцаагч болон холбогдох ажилтнууд энэ дээр хамтраад ажиллаад явж байгаа. Гадагшаа гарсан мөнгө бүгд орж ирэхгүй байна, дансаар орж ирэхгүй байна энэ нь төлбөрийн тэнцэл дээр нөлөөлж байна гэсэн зүйлс яригдаж байна. Энэ дээр Төв банк хэд хэдэн бодлогын арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа. Мэдээж хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Валютын зохицуулалтын тухай хууль болон бусад хууль, эрх зүйн актуудын хүрээнд бид бүхэн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн бизнесийн орлогыг дан ганц Монгол Улсын арилжааны банкаар дамжуул гэсэн зохицуулалт байхгүй байгаад байгаа юм. Валютын зохицуулалтын хуулиар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх л аж ахуйн нэгжүүд гүйлгээ болон бусад санхүүгийнхээ үйл

ажиллагааг өөрсдийн сонгосон санхүүгийн институт, институтууд дээр бүгдээрэнг нь аваад ашиглаад явж байгаа.

Таны яг асуусан асуулт дээр яг тэр өнгөрсөн жилийн 10 дугаар, 9 дүгээр сард байгуулагдсан Засгийн газрын 362 дугаар тогтоолоор батлагдсан Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх тухай ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Энэ хүрээнд хилээр гарсан нүүрсний болон ашигт малтмал олборлосон орлогыг бүрэн гүйцэд орж ирэхгүй байна гэсэн тийм мэдээлэл гарсан. Энэ хүрээнд Төв банк хил гааль болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гаалийн байгууллагуудтай хамтарсан мэдээллийг дүгнээд үзэхэд ойролцоогоор 2 тэрбум орчим долларын тийм яг бодит хэмжээгээр мөнгөн дүнгээр орж ирээгүй тийм дүнгарсан байгаад байгаа.

Тэгэхээр энэ дээр тодорхой хэмжээн дээр дийлэнх хэсгийг нь оффтек болон бусад энэ төмөр зам гэх мэтчилэн бусад энэ төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлээд бартерын журмаар орж ирсэн байгаа гэдэг дээр Засгийн газраас бай.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 2 номерыг дахиад сунгая. 1 минут.

**Г.Дөлгөөн:** Орсон тэр гадаад улсуудад гарсан мөнгөний тэр тодорхой хэсгийг нь тэр оффтек болон бусад энэ бартерын журмаар бараа бүтээгдэхүүн болж орж ирсэн гэдэг талаар холбогдох байгууллагуудад мэдээлэл өгсөн байгаад байгаа. Тэгэхээр мэдээж тодорхой хэмжээнийх нь мөнгө нь яг ингээд улсын юу гэдэг юм Монгол Улсын арилжааны банкнуудын дансаар орж ирээгүй байна гэсэн дээр яг тийм тайлбар өгөхөд ийм байна.

Ипотекийн зээлийн хувьд бид бүхэн 2023 онд Төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн хүрээнд оны эхний хагаст багтаагаад Засгийн газарт ипотекийн зээлийн хөтөлбөрийг

шилжүүлэх талаар бид бүхэн Сангийн яам болон Барилга, хот байгуулалтын яамтай хамтраад ажиллаад явж байгаа.

Яг одоогийн байдлаар бол 2 дугаар улирал эхлэхэд 10 орчим хоногийн хугацаа байна. Манай зүгээс Барилга, хот байгуулалтын яамны мэдэлд шилжүүлэхээр ажиллаад явж байгаа. Ер нь хугацаандаа багтаад шилжинэ. Ипотекийн зээлийн.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Тодруулах уу. 2 номерын микрофон дахиад 1 минут сунгая.

**Г.Дөлгөөн:** Ипотекийн зээлийн мэдээж хүртээмжийг нэмэгдүүлэх ипотекийн зээлийн тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд Төв банк, Засгийн газар хамтраад энэ дээр нэлээн хэд хэдэн бодлогын арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа. Үүний үр дүнд төвлөрлийг сааруулах хөдөө орон нутгийн бүсчилсэн хөгжлийг дэмжих Хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутагт ажиллаж, амьдарч байгаа иргэдийн ипотекийн зээлийн тодорхой эх үүсвэрийн урьдчилгаа төлбөрийн тодорхой хувийг татаастай хэлбэрээр дэмжлэг хэл буюу 3 хувийн хүүтэйгээр олгох гэх мэтчилэн орон нутагт олгогдож байгаа ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээнүүдийг Төв банк болон Засгийн газраас авч ажиллаж байгаа.

Ер нь цааш цаашид ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, илүү боловсронгуй болгох, илүү зорилтот зах зээл дээр чиглэсэн хэлбэрт нь шилжүүлж өгвөл ипотекийн зээлийг бол өргөжүүлж явах нь Төв банкны бодлого байх болно. Тэгэхдээ 2023 оны хагас жилээс эхлээд Засгийн газарт.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Тодруулах уу. Баттөмөр гишүүний микрофоныг.

**Б.Баттөмөр:** ФАТФ-ын хар жагсаалтаас бол тэр өргөтгөсөн яах вэ

гарах нь гарсан, тэгэхдээ өргөтгөсөн хяналттай улсуудын жагсаалтад Монгол Улс байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Худлаа юм байна шүү дээ тийм ээ. Бүрэн гарчихсан гэж өөрийн чинь хариултад бүрэн гарсан гэж ойлголоо шүү дээ тийм ээ. Энийгээ тодруулаарай. Би зүгээр тэр надад байгаа мэдээллээр бүрэн гараагүй, өргөтгөсөн хяналттай улсуудын жагсаалтад байгаа, 2022 оноос Монгол Улсын энэ гарал үүслийг бизнесийн эцсийн өмчлөгчийг тогтоох чиглэлд ажиллаж байгаа гэсэн ийм мэдээлэл тэр ФАТФ-ын тэр мэдээлэл дотор байлаа шүү. Тэгээд энэ зөрүүтэй л юм явж байна даа. Энийгээ ярих ёстой байх.

Хоёрдугаарт нь Монгол Улсын энэ уул уурхайгаас бусад салбар бүгд өр үйлдвэрлэж байгаа шүү дээ. Тийм ээ 1.5 тэрбум долларын өр жилд үйлдвэрлэж байгаа. Энийг өр үйлдвэрлэхгүй болох чиглэлд энэ мөнгөний бодлогоор энэ Монголбанк юу гэж үзэж байгаа вэ. Танай тайланд байж байгаа шүү дээ 1.5. Уул уурхайгаас бусад нь аялал жуулчлал, тэр боловсрол, эрүүл мэнд бүгд.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ. 2 номер Энхтайван Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч.

**Г.Энхтайван:** Баттөмөр гишүүний асуултад тодруулъя. Тэр ФАТФ-ийн жагсаал эцсийн өмчлөгчийг тодруулахтай холбоотой асуудал бол яг дэлхийн бүх оронд яг одоогийн байдлаар яг тулгамдсан асуудал болоод байгаа. Мэдээж Монгол Улсын арилжааны банкаар явагдаж байгаа гүйлгээн дээр яг тухайн гүйлгээ хийгчийн эцсийн өмчлөгчийг цаг тухайд нь тодорхойлох. Эцсийн өмчлөгч нь ямар хүн байна халхавч байдлаар тухайн гүйлгээ явж байна уу гэдэг дээр энэ сан олон улсын энэ мөнгө угаахтай тэмцэх байгууллагууд тухай бүрд нь хяналт тавиад явдаг.

Яг одоогийн байдлаар Монгол Улс мөнгө угаах, терроризмтой тэмцэх байгууллагын ямар нэгэн тийм хяналтад байхгүй байгаад байгаа. Бусад, ямар нэгэн хяналтад байхгүй байгаа гэдэг нь бусад бүх гишүүн орнуудтай адилхан ердийн нөхцөлтэй хяналтад байгаад байгаа. Тухай бүрдээ цаг тухайд нь хяналт явж байгаа. Уул уурхайн салбарт салбарын энэ хөгжил нь бусад салбарынхаа хөгжил дээр бас нөлөөлж байгаа асуудал байгаа. Энэ дээр төв банк нэлээн хэд хэдэн бодлогын арга хэм.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Болсон уу. Ганибал гишүүн асуулт асууж, үг хэлье. Ганибал гишүүний микрофоныг нээе.

**Н.Ганибал:** Одоо тэгээд Монголынхоо банкир, банкируудын ач тусаар Монголчууд их наяд гэдэг сайхан тоог бүгдээрээ сурсан. 12 оноос хойш дотоодын нийт бүтээгдэхүүн маань 4000-аас тэгээд ер нь бараг царцсан даа тээ одоо 5000 руу орж байгаа. Яах вэ тэгээд банкнуудын ч систем, энэ Засгийн газрын бодлогуудын алдаатай, төр засгийн бодлогын алдаа. Зүгээр бид нар ийм тоо сураад байгаа болохоос бодит эдийн засаг маань өсдөггүй ийм л амьдрал руу бүгдээрээ орчихлоо. Тэгээд хэд хэдэн асуудал байна.

Энэ 10 их наядад Засгийн газрын гаргасан энэ 10 их наядын хөтөлбөр ер нь Монгол Улсын эдийн засагт нөлөөгөө өгсөн юм болов уу. Энэ тал дээр ер нь Монголбанк юу гэж үздэг юм. Цаашилаад ингээд Монголбанкны бодлогын хүү өндөр байхад бас л Засгийн газар эргээд л нөгөө хүнсний хувьсгал гээд л 1 их наядын хөтөлбөр гаргаж ирээд л тавьчихаж байгаа байхгүй юу. Ингээд ийм нэг салбар нийт юу гэдэг юм эрүүл мэндийн оношилгоогоо зөв тавиад бүгдийг нь эрүүлжүүлэх биш, улам л ингээд л хэсэг хэсгээр нь жижигхэн жижигхэн ийм бодлогууд авч явсаар байгаад бид нар ийм ямар ч гэх юм бэ дээ энэ. Энэ бодлогууд ер нь зөв юм уу, буруу юм уу. Та бүхэн бас юу гэж хариулт өгсөн юм.

Ингээж явах нь зөв үү, буруу юу гэдэг дээр.

Өнөө энэ жилийн хувьд Монгол улс яах вэ ер нь 6 сар л бүтээн байгуулалтын ажлуудаа хийдэг, бусад цагт нь ерөнхийдөө бараг амардаг шахуу улс орон шүү дээ. Тэгээд энэ жилийн хувьд бол төсвийн хөрөнгө оруулалт гэж байхгүй Хэмнэлтийн хуулиар царцаагдсан шинээр. Яг энэ цаг хугацаанд бас энэ барилгын салбар маань нэлээн хүнд нөхцөл рүү орчихлоо. Сая Баттөмөр гишүүн маш тодорхой л асуугаад байна л даа. Ипотекийн зээл байхгүй байна. Ер нь олдохгүй байгаа шүү дээ. Эргэлдэж байгаа мөнгөө аваад хуримтлалаараа буцааж өгч байгаа л гэж ярьж байгаа.

Гэхдээ яг тэр салбар чинь тэгж хэн нэгэн ипотекийн зээл авах гэж хүмүүсээс арилжааны банкны нөлөө бүхий хүмүүсээс гуйж амьдардаг ийм зах зээл болчихсон байхгүй юу. Энийг яаж хурдан засах юм бэ. Тэгээд Засгийн газар нь эргээд Хөдөөгийн сэргэлт гээд сайхан ярьж ярьж байгаад хөдөө очсон хүнд 3 хувийн зээл өгнө гээд хэлчихсэн. Мөнгө байхгүй, бодлого байхгүй байж байж ийм амлалтууд Засгийн газар өгөөд байна. Та нарыг бас хорлоод байгаа байхгүй юу. Тэгээд энэ хорлож байгаа үед нь та нар янз бүрийн юм ер нь Засгийн газар тэр тал дээр нь зөвлөмжүүд уг нь хүргүүлэх ёстой л доо Их Хурлаар дамжуулж хүргүүлэх юм уу өөрсдөө шууд хэлцэл хийх ёстой юм уу. Энийгээ яагаад энэ ажлуудаа та нар хийхгүй байна. Энэ дээр л гол үймүүлээд, сахилгагүй айл чинь тэр Засгийн газар байна шүү дээ. Тэгээд тэр сахилгагүйтээд байгааг нь та бүхэн хязгаарлах ёстой Их Хурлаар дамжуулж, тэгээд энэ дээр явж энэ хязгаарлалтууд дээр нь та бүхэн бас жоохон хүчтэй оролцооор байна гэсэн саналыг хэлье.

Тэгээд энэ асуудлууд дээрээ хариулт авъя. Одоо цалингийн цалин, тэтгэврийн нэмэгдүүлэх асуудал дээр та нар бас дуугүй л байсан. Тэгээд дараа нь эргээд л бид нарт гоё шинэ тоо л

цээжлүүлэх байх даа. Их наядын ард юу байдаг юм бол доо. Тэгэхээр энэ асуудлууд дээр та нар жоохон Монгол Улсаа бодож энэ улс төрөөс биш, яг эдийн засаг талаас нь энэ эх оронч жоохон сэтгэлтэй хандмаар байна гэсэн. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Банкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Дөлгөөн хариулъя. 3 дугаар микрофон.

**Г.Дөлгөөн:** Ганибал гишүүний асуултад хариулъя. 10 их наядын цогц төлөвлөгөөтэй холбоотой асуудал асууж байна. Товч хэрэгжилтээс дурдахад нийтдээ 4 цогц хөтөлбөр явагдсан, төлөвлөгөө явагдсан байгаа. Үүний эхнийх нь ажлын байр дэмжих зээлийг 2 их наядаар гаргахаас тухайн үедээ буюу 21, 22 онуудын хувьд арилжааны банкаар дамжуулаад төв банкнаас ямар нэгэн мөнгөний нийлүүлэлт хийхгүйгээр арилжааны банкны цэвэр өөрсдийн эх үүсвэрээр 1.9 их наядын зээл гарсан.

Дараагийнх нь урт хугацаат репо санхүүжилтийг бас 2 их наяд гаргахаас төлөвлөж байснаас 1.3 их наяд энэ бол өөрөө төв банкнаас санхүүжүүлсэн санхүүжилт байгаа.

Гурав дахь нь орон сууцын ипотекийн зээл байгаа. Орон сууцын ипотекийн зээл маань сүүлийн 3, 4 жилийн хугацаанд ялангуяа КОВИД-ын нөхцөл байдалтай үед эдийн засгийг эрчимжүүлэхийн хүрээнд энэ хөтөлбөрт хамрагдаад дээр нь КОВИД-ын хуулийн гол нэг заалт болох ипотекийн орон сууцын энэ зээлийг төв банкнаас санхүүжүүлнэ гэсэн энэ заалтын дагуу 22 оны 12 сарын 31 хүртэл Төв банк энэ хэрэгжилтийг хангуулж ажилласан.

Гурав дахь нь хөдөө аж ахуйн зээл 880 тэрбум төгрөг гаргахаас 789 тэрбумыг гаргасан байгаа. Хэрэгжилтийг товч дурдахад нийт саяын 4 цогц төлөвлөгөө маань нийлээд нийтдээ 5.9 их наяд гарснаас өнөөдрийн байдлаар ажлын байр дэмжих зээл 1.9

гарснаас 878 тэрбумын үлдэгдэлтэй, чанаргүй зээл нь 4.5 тэрбум төгрөг буюу 1 хувьд нь хүрэхгүй байгаа. Репо санхүүжилт бол 1.3 их наяд гарснаас нийт үлдэгдэл нь 785 тэрбум төгрөг чанаргүй зээл нь 7 тэрбумын үлдэгдэлтэй байгаа. Хөдөө аж ахуйн зээлээс 789 тэрбум гарснаас нийт үлдэгдэл нь 50 хувь багасаж, 363 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй чанаргүй зээл нь 27 тэрбумын үлдэгдэлтэй байна.

Тэгээд үндсэндээ энэ төлөвлөгөө маань амжилттай явагдсан бөгөөд саяын миний өмнөх тайланд дурдсанаар тухайн үед уул уурхайн салбарын өсөлт төдийлөн саарсны хажуугаар үйлдвэрлэх, боловсруулах энэ үйлдвэрүүд худалдааны чиглэл маань үйлчилгээний чиглэл маань нэлээдгүй амжилттай гарч 4.8 хувийн дотоодын нөхцөл бүтээгдэхүүний өсөлттэй гарсан гэж байгаа. Энэ нь бол 10 их наядын цогц төлөвлөгөө шууд утгаараа нөлөө үзүүлсэн байна гэдгийг төв банкны зүгээс үзэж байгаа.

Ипотекийн зээлтэй холбоотойгоор сая түрүүн бас хэлсний дагуу КОВИД-ын хуулийн дагуу бид бүхэн энэ санхүүжилтүүдийг 22 оны 12 сарын 31 хүртэл өгөөд явсан. Төв банкны хуульдаа аливаа төсвийн шинжтэй санхүүжилтэд Төв банк оролцохгүй гэсэн энэ хуулийн заалтыг 23 оны 1 сарын 1-нээс бид бүхэн хэрэгжүүлээд энэ хөтөлбөрийг Засгийн газар руу шилжүүлэхээр Барилга, хот байгуулалтын яамтай хамтраад ажиллаад явж байгаа. Эргээд Монголын ипотекийн корпорац дээр нь банкны өөрсдийн эх үүсвэр эргэн төлөлттэй холбоотойгоор энэ санхүүжээд явна. Дээр нь нэмээд гол бодлого маань Засгийн газартай буюу Барилга, хот байгуулалтын яаман дээр гол бодлого маань зангидаад явна гэдэг ийм хүлээлттэй байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлье.

**О.Цогтгэрэл:** Хоёр зүйл байна. Монголбанкны тайлан гээд нэлээн зузаан материал тоо баримттай. Энэний цаана бид нар тоо баримт багатай ярьдаг зарим зүйлүүд бас байгаад байна. Тэр нь ер нь Монгол Улсын далд эдийн засаг өнөөдөр яг ямар байдалтай байгаа вэ. Та нар энэ дээр ямар тоо, тооцоололтой байдаг юм. Бусад улс оронтой харьцуулахад манайх шиг түвшиний оронтой харьцуулахад энэ нь өндөр үү, бага уу. Мэдээж далд эдийн засаг гээд зүйл ярихаасаа урьдаар та нарыг жаахан энд тодорхой төвлөрч ярьж өгөөч ээ л гэж хүсэж байна. Жишээ нь энэ далд эдийн засгийн шалтгаан нь ер нь юунд байдаг юм. Татварын их, багад байдаг юм уу. Янз бүрийн хууль бус орлого их болсон улс оронд эдийн засгийн далд байдаг юм уу.

Цаашидаа Монголбанкны зүгээс энэ далд эдийн засагтай ямар бодлого чиглэлээр ажиллах ер нь төлөвлөгөөтэй байдаг юм. Хэрвээ энэ далд эдийн засаг тодорхой хэмжээгээр ил болоод гарвал эдийн засагт тэр эерэг нөлөөллүүд олон зүйлээсээ юу хүлээгдэж байгаа юм энэ дээр. Уул уурхайн салбар, олон уул уурхайн салбарын борлуулалтаас эхлээд олон талт энэ авлигын эх сурвалж болчхоод байна далд авлигал их байгаа учраас далд эдийн засаг өндөр түвшинд байгаа гэдэг янз бүрийн л тоо баримтууд. Зарим нэг судлаачдын мэдээллээс харахад далд эдийн засаг Монгол Улсад өсөж байгаа гэсэн зүйлийг ч бас ярих судлаачид бас байна лээ. Тэгэхээр энийг тойроодтодорхой бас мэдээллүүд өгөөч.

Хоёр дугаарт нь иргэдийн болоод энэ орлогын ялгаа гэдэг зүйл Монгол Улсууд ямар байгаа юм. Тэр жини индекс, жини коэффициент гээд тооцдог аргачлалууд ч байдаггүй байх. Монгол Улсад энэ орлогын ялгааг яаж тооцдог юм бодит судалгаанууд болоод дүгнэлтүүд сүүлд хэзээ гарсан юм, яг өнөөдөр ямар байгаа юм, дахиад энэ нь өөрөө хандлага нь ямар байгаа юм. Дэлхийтэй, манайтай адил төстэй улс

орнуудад энэ нөхцөл байдал бас ямар байгаа бол. Эдгээр дээр тодорхой мэдээллүүд өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ. 4 номерын микрофон. Нэрээ хэлээрэй.

**Д.Ган-Очир:** Сайн байцгаана уу. Монголбанкны ерөнхий эдийн засагч Ган-Очир. Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Яг далд эдийн засгийн хувьд бол Монголбанк бол тусгайлан яг хариуцдаггүй. Гэхдээ Монголбанк дээр бол судалгаа, шинжилгээний нэгжүүд маань бол энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний үр дүнг бол гаргаж танилцуулдаг байгаа. Эндээс харахад бол Монголын далд эдийн засгийн хэмжээ бол 20-30 хувьтай гээд судалгаа болгон дээр бол ээн интервалын орчимд бол үр дүнгүүд бол гарч байгаа.

Ерөнхий хандлагын хувьд бол хамгийн сүүлд хийсэн судалгаа бол 17 оны судалгаа байгаад байгаа. Үүгээр бол 30 орчим хувьтай байна гэдэг ийм судалгааны үр дүн байгаа. Олон улсад бол энэ далд эдийн засгийн хэмжээг сайн, сөрөг, эерэг талаас нь аль алинаар нь бас харж үзэж байгаа. Мэдээж сөрөг тал бол энэ татварын орлого, ил тод бус байдал байгаа. Энэний хойно бол таны сая хөнддөг энэ орлогын ялгаа, шударга бус байдал гэдэг юм уу энэ зүйлс бас давхар нуугдаж байна гэдэг асуудлаар сөрөг үр дагавруудыг хардаг.

Эерэг үр дагавар нь ч гэсэн бас зарим хямралын үед ч гэдэг юм уу. Ийм үед төрийн хэт оролцоотой ийм хямралын үед бол энэ бас зарим талаар бол энэ далд эдийн засаг том, тэр утгаараа бол далд эдийн засгийн дотор албан бус сектор нь өөрөө том байх буюу бүртгэлгүй мөртөө ажиллаж эрхлээд тодорхой хэмжээний орлого олдог ийм бүлэг нэгж бас том байх нь бол хямралын үед бол бас тодорхой хэмжээний энэ гаднын сөрөг өөрчлөлтийг бол шингээгээд гарах

*боломж бас бүрддэг юм гэдэг байдлаар ч бас ярьдаг.*

*Мэдээж Монгол Улсын хувьд бол энэ сөрөг үр дагавар нь илүү том гэдэг утгаараа энэ татварын асуудлууд, түүнийг тойрсон энэ орлогын тэгш бус байдлыг бууруулахтай холбоотой асуудлаар бол Засгийн газрын зүгээс бол тодорхой бодлого, чиглэл бариад явж байгаа гэж ойлгож байгаа. Энэ чиглэлд нь бол Монголбанк бол өөрсдийн чиг үүргийн хүрээнд ялангуяа банк санхүүгийн гүйлгээ тэрэнтэй холбогдсон асуудлуудаар нь мэдээж нягт хамтран ажиллах бололцоо нь бол нээлттэй байгаа.*

*Хоёр дахь асуудлын хувьд бол мэдээж таны сая хэлдэг хамгийн гол хэмждэг үзүүлэлт бол жини коэффициентын асуудлаар бол энэ орлогын тэгш бус байдлыг бол хэмждэг гэж олон улсад үздэг. Гэхдээ Монголбанкин дээр хийгдэж байгаа болон бусад энэ Монголд байдаг эрдэм шинжилгээний байгууллага, судлаач нарын гардаг үр дүнгээр бол яг энэ коэффициентыг нь гэдэг юм уу тооцоод үзэхлээр бол тийм том зөрөө бол гардаггүй. Тэгэхэд асуудал нь өөрөө юу юм бэ гэхлээр энэ тооцооллуудыг өрхийн сектор дээр гарч байгаа энэ өөрчлөлтүүдийг тооцох ёстой энэ статистик мэдээллийнх нь чанарыг нь сайжруулах ёстой юм байна гэдэг нь бол хамгийн чухал байгаад байгаа.*

*Яагаад гэвэл энэ бүх тооцооллыг хийдэг гол зүйл нь бол түүвэр судалгааны аргуудаар өрхүүдийн орлого, зарлагуудыг нь бол өрхүүдээр сонгож авсан өрхүүдийн хүрээнд анкет бөглүүлж авдаг гэсэн үг. Тэгэхээр энэ ирдэг мэдээлэл нь бол яг тэр өндөр орлоготой бүлгүүд бол тэр түүвэр судалгаанд нь гүйцэд хамрагддаггүй, эсвэл орлого багатай хэсэг нь хамрагддаггүйгээс болоод тэр дундаж орчмынх нь бүлэг гэдэг юм уу нэгдмэл ижил тархалттай хэсэг дээр нь тоон мэдээлэл авч байгаад ялгааг нь тооцдог энэ олон улсын аргачлалаар*

*тооцохлоор бол нийт их том зөрүү нь бол харагддаггүй.*

*Гэхдээ мэдээж яг тэндээ хандлагыг нь аваад үзэх юм бол тэр индекс бол бага зэрэг орлогын тэгш бус байдал өсөж байгаа гэдэг үзүүлэлтийг бол харуулах чиглэлд өөрчлөгдөж байна гэдэг энэ зүйл бол байгаа. Мэдээж банк, санхүүгийн үзүүлэлтүүдээр бол нийт хадгаламжийг хэдэн хадгаламж эзэмшигч эзэмшиж байна ч гэдэг юм уу, эсвэл энэ үнийн өсөлт нь орлогын ялгаатай бүлгүүдэд очиж байгаа өрхийн зарлагын бүтэц нь ямар хэмжээний дарамт үзүүлж байна ч гэдэг юм уу энэ үзүүлэлтүүдээр нь мэдээж бид бүхэн бас энэ асуудлыг хардаг. Тэгээд энэ асуудлыг энэ өнцгөөс нь аваад үзэх юм бол энэ үнийн өсөлт ч гэдэг юм уу, нийгэм эдийн засаг дээр гарч байгаа ялангуяа орлогод нөлөөлөх том өөрчлөлтүүд бол орлого багатай бүлэг дээр бол илүү хүнд тусаж байна. Энэ нь орлогын тэгш бус байдлыг бол өсгөх чиглэлд бол илүү нөлөөлдөг юм байна. Ялангуяа хямралын дараагийн жилүүд дээр бол энэ өөрчлөлт нь бол илүү тод байдаг байна гэдэг энэ олон улсын хандлага ч Монгол Улсад ижил байна гэдэг судалгааны дүнгүүд бол гардаг байгаа. Баярлалаа.*

**Ж.Бат-Эрдэнэ:** Цогтгэрэл гишүүн тодруулья.

**О.Цогтгэрэл:** Тэр далд эдийн засаг дээр шалтгаан, нөхцөл ямар шалтгаанаас болж далд хүмүүс орлогоо нуун дарагдуулах нөхцөл байдал их үүсдэг вэ гэдэг асуудлын гол нь байх л даа. Жишээ нь татвар өндөр учраас тэгдэг юм уу, аль эсвэл тэр авлигатай холбоо, аль эсвэл тэр бага орлого олдог хүмүүс тэр бүртгэлийн асуудал тэрэнтэй холбоотой зардал чирэгдэл, нягтлан бодох бүртгэлээс эхлээд тэр чадамжийн асуудлаас болоод байна уу.

*Тэгэхээр энэний цаана шалтгаан руу орж асуудлуудыг л бас тодорхойлох шаардлага үүсэх байх л даа. Тэгээд эндээс ер нь Монгол Улс өөрөө та нарын*

судалгаа, дүгнэлтээр татварын ачаалал хэр зэрэг орон бэ. Манайх чинь 4, 10-ын татвар л гэдэг. Нийгмийн даатгалын татвар маань явсаар байгаад татвар болоод хувирчихсан ийм нөхцөл байдлуудтай байдаг. Тэгэхээр энэ бүгдийг ингээд харьцуулаад үзэхээр Монгол орон өөрөө Монголбанкны дүгнэлтээр бол татварын ачаалал.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ далд эдийн засагтай холбоотой асуудлаа жоохон тодорхойхон шиг ярьчихаач. 4 номер.

**Д.Ган-Очир:** Яг хийгдсэн судалгаа шинжилгээнийхээ үр дүнг л хуваалцаж байгаа. Яг гүнзгий бол орж чадаагүй учраас нарийн мэдээлэл өгч чадахгүй байгаадаа бас хүлцэл өчье. Бид бүхний судалгааны олон улсын харьцуулалтаас бол хамгийн гол шалтгаан бол мэдээж танийн хөндөж байгаа л хоёр асуудал.

Татвар маань ялангуяа өсөн нэмэгдэх шинж чанартай юм уу болох, эсвэл яг тэр нь компанийн түвшин ч байсан, өрхийн түвшин ч байсан гэсэн энэ бол өөрөө энэ татвараас зугтаах хамгийн гол шалтгаан байна гэдэг асуудал. Мэдээж энэ асуудлынх нь хүрээнд мэдээж бүртгэлийн асуудлууд байгаа. Тэр татварын болон хөрөнгүүдийн бүртгэлийн асуудлууд байгаа. Тэгээд энэ чиглэлд нь бол нөгөө Монгол Улсад дутагдаад байгаа олон улсад байдаг хамгийн гол жишээ бол хүн орлого олсон бол тэр бүх орлого нь татварын дугаар болон бизнес эрхэлдэг дугаараараа хаа нэгтээ бүртгэгддэг, тэр нь татварынхаа албан дээр очдог.

Тэгээд жилийн эцэст болохлоороо чи төлөх ёстой татвараасаа өндөр төлсөн байна буцаалт авдаг, эсвэл чи төлөх ёстой татвараасаа бага татвар төлсөн байна гээд нэмж төл гэдэг ийм бүртгэлийн дэд бүтцийг Монголд яг орлого. Тэр нь өөрөөр хэлбэл валютын ханишийн хэлбэлзлээс болж орлого олсон байна уу, үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөнөөс болж орлого олсон байна уу

гэдэг юм уу энэ бүх орлогуудыг нь бид нар бүртгэж чаддаг ийм тогтолцоо руу бид бүхэн орох ёстой. Орлого олж л байгаад л бүртгэгддэг. Монголд бол жишээ нь тэгэхэд валютын ханишийн хэлбэлзлээс ч юм уу, үл хөдлөх хөрөнгийн орлогоос нэмэгдэж олж байгаа тэр капиталын ген гэж хэлээд байгаа тэр хэлбэлзлээс нь олдог орлогууд гэдэг юм уу тийм бүртгэлийн системүүд маань хангалттай биш байгаа.

Тэгэхээр энэ чиглэлд яалт ч үгүй энэ татварын дэд бүтцийг сайжруулах асуудал бол маш чухал байгаа гэдгийг хэлье.

Хоёр дахь асуудал бол энэ татварын ачаалалтай холбоотой зүйлс дээр бол Монголбанк яг нарийн эксперт бол биш. Гэхдээ энд тэнд хийгддэг судлаач нар судалгааны үр дүнгүүдийг авч үзээд бүлгүүдээр нь авч үзэхэд бол Монгол Улс бол яг татварын ачааллынхаа хувьд бол өндөр бус гэдэг тэр ангилалд багтдаг гэдэг тийм олон улсын харьцуулалт судалгааны үр дүнгүүд бол явж байгаа. Тэгэхээр тэр мэдээллийг л энд хуваалцаж чадахаар байна. Түүнээс яг эцсийн дүгнэлт юм уу, албан ёсны Монголбанкны байр суурийг энэ дээр илэрхийлэх боломжгүй байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Доржханд. Даваасамбуу гуай 1 номерын микрофон дээрээс нэмээд хэлчих дээ, нэмээд хариулчих.

Тэр татвартай холбоотой асуудлууд, тэр бүртгэлийн системийг бий болгох шаардлагатай гээд байгаа шүү дээ энэ дээр тэгээд Монголбанк ямаршуу байр суурьтай байх ёстой юм тэрийг бас нэмээд явчихъя. 1 номерын микрофон.

**Д.Даваасамбуу:** Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга Даваасамбуу байна. Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэлийн тавьсан асуудлаар зарим санааг хэлье.

Тэгэхээр юуны өмнө энэ орлогоо яагаад нугаад байна, бид далд эдийн засгийг яаж илрүүлэх вэ гэдэг асуудлыг хөндлөн тавьж байна гэж би ойлголоо. Тэгэхээр юуны өмнө бид татварын түвшин бол дэлхийн жишигтэй харьцуулахад дундаж буюу дунджаас доогуур л даа нийт дүнгээрээ. Тийм дүгнэлт гардаг юм байна лээ. Тэр орлогоо яагаад нугаад байна гэхээр зэрэг бид нар энэ орлогоо бүртгүүлэх, орлогоосоо өөрөө аваад ашиглах, мөн орлогоо нийтэд мэдээлэх сонирхол механизм нь бүрдээгүй байгаа учраас энэ ажил нэлээн доогуур. Ажил эрхэлсэн л бол орлогоо төлөх ёстой, бүртгүүлэх ёстой энэ журам маань хэрэгжиж чадахгүй байгаа юм. Ганцхан жишээ ярина гэхэд бид нийгмийн даатгалын шитгэлийг ярьж. Над дээр 500 мянган төгрөгөөсөө шимтгэл өгчхөөрэй, өгч байгаа цалин 3 сая гэдэг л ийм л механизм өнөөдөр үйлчилж байгаа.

Тэгэхээр энэнээс гарч байгаа үндсэн арга зам бол дэлхийн жишгээр бол доор хаяж өндөр настны нийгмийн даатгалын шимтгэл ухаан нь 7 хувь ажил олгогч өрөөгдөг, ажил эрхлэгч өөрөө 7 хувиа өгдөг гэвэл энэ 7 хувийг нь өөрийнх нь хуримтлал болгоод өгчхөж байгаа юм дэлхий, Бүгд Найрамдах Хятадад Улс, Америк энэ бүгд.

Аливаа ажил эрхэлж орлого олж байгаа хүн өөрөө шимтгэлээ авах гэж байгаа учраас өөртөө хуримтлал болгож байгаа учраас бүгдийг нь бүртгүүлж байгаа. Америкийн ухаан нь Бүгд Найрамдах Хятадад Ард Улсад би хэдэн жил ажилласан л даа. Тэнд байгаа байнгын дүрвэж ажилладаг хүмүүс бол юуны өмнө л ерөөсөө орлогоо бүрэн бүртгүүлж, шимтгэлээ авах гээд байдаг юм. Энэ л механизмыг бид зоригтой хийж өгөхгүй бол энэ ажил улам цаашаа хүндэрнэ гэдэг ийм юм.

Дээрээс нь мэдээж бид өнөөдөр энэ КОВИД-той холбогдуулаад бэлэн бус тооцооны ажил их явагдчихлаа. Тийм

учраас энэ Унгарын ч юм уу, Европын Холбооны туршилага бий л дээ. Ажил эрхлэлтийг бүртгэдэг бүх орлогыг бүүр албан ёсоор бүртгэдэг ийм эрх зүйн зохицуулалтаа хийгээд энийгээ нэгдсэн бүртгэлд оруулах гэдэг энэ асуудлуудыг манай сая зарим нөхдүүд ярих шиг боллоо. Тэр орлогын тэгш бус байдал гэдэг дээр Монгол Улс бас их дээгүүр орж байгаа. Азийн хөгжлийн банкнаас жил бүхэн, заримдаа 2 жил болгоод бусад манайтай зэрэгцүүлэх орнуудыг гаргаж тавьдаг юм. Орлогын тэгш бус байдлын талаар. Энийг бас бид би яг өнөөдрийнхийг нь хараагүй учраас хамаагүй яриад хэрэггүй байх зүгээр.

Ер нь тэр үед 7.5 дахин өндөр зөрүү нь. Монгол бол нэлээн өндөр орлогын ялгаа ихтэй орны тоонд орж явдаг юм байна лээ. Түүрэн Батмөнх, хэн гишүүн бас энэ экспортын орлого чинь гадаадад үлдчихээд байгаа юм уу, энэ яагаад гадаад худалдаанаас чинь 3, 4 их наяд 3, 4 их тэрбум доллар ашигтай байхад төлбөрийн баланс чинь алдагдалтай байна вэ, мөнгө нь үлдээд байгаа юм уу, далд эдийн засгаар үлдээд байгаа юм уу гэсэн санаа хэлнэ лээ.

Тэгэхдээ бид нар энэ дээр энэ Монголын эдийн засаг энэ экспортын орлогын ихэнхийг нь юунд зарагдчихаад байна вэ гэдгийг хоёр, гуравхан жишээгээр хэлчихье гэж бодогдоод явчихлаа. Энэ нэгдүгээрт бол Монголд орж ирсэн хөрөнгө оруулалтын эргэх урсгал явагдчихсан. Энэ маань өөрөө зээлийн хүү, үндсэн төлбөр, тэгээд ноогдол ашиг. Жишээ нь 22 онд гэхэд чинь бид зээлийн хүү ноогдол ашгаар 2.2 тэрбум ам.доллар гарч байгаа юм. 2.2 ам.доллар тэрбум доллар. Дээрээс нь гадаад худалдааны тээврийн зардал. Бид чинь машинаар тээж байгаа шүү дээ. Үүнд га гарч байгаа мөнгө маань өөрөө 1.4 тэрбум доллар шүү дээ. Бүх төрлийн тэг.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Хугацаа дууслаа. Доржханд гишүүн, Доржханд гишүүний микрофоныг өгье.



**Т.Доржханд:** Баярлалаа. Нэгдүгээрт энэ Монголбанкны Ерөнхийлөгч маань хаана байна. Тэр нэг хариулт авчихмаар байна. Яагаад вэ гээд тэгэхлээр яг энэ тайлан хэлэлцэж байх үед чинь би асууна шүү гэж энэ 2022 оны мөнгөний бодлого ярьж байх үед хэрвээ та нар бичлэгээ ухрааж үзэх юм бол яг ингэж асууж байсан юм. Яагаад вэ гээд тэгэхлээр 2022 онд манай Монголбанк тухайн үеийн Засгийн газрын нөхдүүд их сайхан сайхан юм яриад байсан л даа. КОВИД ингээд дуусаж байна. Цаашаагаа эдийн засаг V- shar-ээр явна, W shar-ээр явна, өснө асуудал байхгүй, инфляцыг бид нар б+, -2 гэдэг энэ коридортоо багтааж чадна гээд. Цадах уу гэсэн чадна гээд. Хариуцлага чадахгүй бол хариуцлага тооцож болох уу гэсэн болно л гэж байсан шүү дээ.

Гэтэл 2022 онд инфляц хэд байсан юм бэ. 13.2 оны сүүлд гэсэн байх, оны дундуур энэ чинь 17 хүрч байсан. Дунджаар 15 хувьтай. Тэгээд худлаа мэдээллээр Улсын Их Хурлыг хангадаг, оруулж ирж бодит биш төсөөллийг батлуулдаг тэгээд үр дүн нь хүрдэггүй араас нь маш их тайлбар хийдэг энэ байдлыг яаж засах вэ. Хариуцлага хүлээх үү. Яг тухайн үед энэ гурван дарга нь гурвуулаа орж ирж байсан. Лхагвасүрэн, энэ Дөлгөөн, тэр Энхтайван эд нар. Лхагвасүрэн нь тэгээд л аргалаад л өнгөрч байсан байхгүй юу. Одоо 2023 оны гүйцэтгэл мөн л ялгаагүй инфляцаас 8 хувийн зорилт тавьчихсан 2 оронтой тоотой л гарна шүү дээ.

Тэгэхээр энэ байдалд хариуцлага хүлээх үү гэж байгаа юм. Хүлээдэг юм байгаа билүү энэ чинь. Та нар маань юу билээ. Тэгээд худлаа тоо ярьдаг тэрийгээ баталдаг байдлаар Улсын Их Хурал яваад байх юм уу гэж энэ дээр хариулт авчихмаар байна.

Хоёрт нь энэ нөгөө гоё гоё нэртэй хөтөлбөрүүдээс чинь болоод л Монгол Улс дампуураад л дампуурсан байдалтай л байгаа шүү дээ. Улс төрждөг сонгууль

дөхөөд сайхан хөтөлбөрүүд явуулдаг тэгээд энэ хөтөлбөрүүдээ боль. Төсвийн шинж чанартай асуудлуудаа бүгдийг нь зогсоо л гээд байгаа юм. Тэгээд ипотекийг шилжүүлэх хэрэгтэй Засгийн газар руу шилжүүлэх хэрэгтэй гээд явж байгаа тэр процесс юу болж байна. Тэрэн дээр мэдээлэл өгөөч. Энэ КОВИД-ын үед гээд баахан элдэв хөтөлбөрүүд хийгээд байсан тэр маань КОВИД-ын хууль дуусгавар болсонтой холбоотойгоор бүгдээрээ зогссон юм байгаа биз дээ. Зогсоогүй үргэлжлээд явж байгаа юм уу энэ дээр хариулт авмаар байна.

Одоо цаашаагаа инфляцаа яах вэ, ханишаа яах вэ. Монголбанкны үндсэн зорилго юу юм бэ гээд төгрөгийн тогтвортой байдлыг хангах гээд. Төгрөгийн тогтвортой байдал гээд тэгэхлээр та нар бид нарт ханишаа хамаагүй шүү, төлбөрийн баланс, экспорт, импорт хамаагүй Засгийн газрын асуудал, бид нарт инфляц л чухал гээд байдаг. Гэтэл инфляцаа та нар ингээд алдчихаад байна. Цаашаа энэ оны хүлээлт төсөв маань 1.8 их наядаар дахиад хэлчихлээ дахиад шууд cash гарлаа. Энэ чинь эргээд инфляц дээр нөлөөлнө. Ханишаа бас тогтворжуулахад бас нөлөөлнө тодорхой шүү дээ энэ чинь. Эдийн засгийн онол нь байгаа юм чинь.

Тэгээд энэ тохиолдолд Монголбанк яг ямар хариу арга хэмжээ авах юм бэ. Бодлогын хүү өсгөх юм уу, мөнгөний бодлогын ямар арга хэрэгсэлгүй та нар төлөвлөж байгаа юм, Засгийн газартайгаа ярьсан юм уу. Тэгээд жил болгон төсвөө тэлдэг тэрэнд нь та нар гонгиносоор байгаад ямар ч үүрэг оролцоо байдаггүй. Араас нь олон юм яриад байдаг, орж ирээд зоригтойнхон ч юмаа хамгаалж чаддаггүй. Тэгээд л үр дүнд нь инфляц нь ч өсөөд байдаг. Үр дүнд нь бодлогын хүүгээ өсгөдөг, үр дүнд нь хувийн сектор, бизнесийн зээл авч чаддаггүй ингээд л төсвөөс санхүүждэг 90 оноос өмнөх нэг төртэй төлөвлөгөөт эдийн засаг руугаа ингээд ороод л улам томроод яваад байна шүү дээ. Тэгээд энэ

дээр улс бас төв банкнууд зоригтойгоор энийг эсэргүүцээд явдаг байхад би сая Монголбанкны дуу хоолой ерөөсөө сонссонгүй. Тэгээд цаашаагаа Энэ институт чинь ийм байж явахад чадах юм уу. Бие даасан байдал бай.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч Дөлгөөн хариулъя. 3 дугаар микрофон.

**Г.Дөлгөөн:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Төв банкны ерөнхийлөгч Лхагвасүрэн өнөөдөр хурал давхацсан байгаа болохоор миний бие орлож ирлээ.

Мөнгөний бодлогын хувьд бол бид бүхэн 2023 оны 2 дугаар улирлын хурлын эхний хуралдаанаа хийсэн байгаа. Тэгээд эхний хуралдааны 2 дахь хурал хийсэн бөгөөд 2 дахь хуралдаанаар бид бүхэн дараагийн улиралд хэрэгжих мөнгөний бодлогын хүүгийн түвшнийг бид бүхэн тогтоож өгнө.

Гэхдээ өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн тодотгол болон бусад хүчин зүйлстэйгээ хамааралтайгаар бид бүхэн шийдвэрээ гаргаж явна. Өмнөх 22 онд батлуулсан буюу 23 оны мөнгөний бодлогын энэ гол зорилт маань бид бүхэн 1 оронтой тоо руу оруулна гэж ярьж байгаа. Өмнө нь бол хамгийн оргил үедээ 16 хувь хүрч байсан. Өнөөдөр он дуусахад 13.2 хувьтай дууссан хэдий ч өнөөдрийн байдлаар 10.5 хувь буюу гол үнийн сагсан дахь инфляцын хөөргөдөл маань махны дотоодоос шалтгаалсан махны үнийн өсөлттэй холбоотойгоор ингэж бид бүхэн тайлбарлаж байгаа. Тэгэхээр энэ ондоо бид бүхэн оны сүүлээр энэ зорилт руугаа хүрэх болов уу гэсэн гол гол бодлогын тохируулгуудыг хийхээр гол төслүүдээ аваад явж байгаа.

Ипотекийн хувьд бол би бас түрүүн хариулж байсан 22 оны 12 сарын 31-нээр бид бүхэн аливаа төсөл, хөтөлбөрт оролцохгүй буюу КОВИД-ын хууль

дуусгавар болсноор төв банкныхаа хуулийг мөрдөөд ямар нэгэн төсөл, хөтөлбөрт оролцохгүй гэдэг нь хуулиа дагаж явах ёстой. Одоогийн байдлаар бас ямар нэгэн тийм санхүүжүүлсэн хэлбэрт ид бүхэн огт шилжээгүй. Ирэх 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар Барилга, хот байгуулалтын яамнаас энэ ипотекийн санхүүжилтүүд эх үүсвэр болон үлдэгдэл энэ багцыг шилжүүлж авах энэ асуудал ирэх 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар орно гэсэн ийм мэдээлэлтэй байна. Нэмэгдэл мэдээллүүдээ Баярдаваа захирал Мөнгөний бодлогын газрын захирлын хувьд бас мэдээлэл өгсөн нь дээр байх.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэд байна 1 үү. 1 дүгээр микрофон.

**Б.Баярдаваа:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Ер нь төв банкны мөнгөний бодлого хэрэгжүүлдэг зарчим дэлхий нийтээрээ бол ирээдүйд үүсэж болзошгүй нөхцөл байдлыг өнөөдрийн шатан дээрээс урьдчилж хараад түүн дээр үндэслэж эдийн засгийн өсөлт, инфляц, төлбөрийн тэнцэл, ажил эрхлэлт гэсэн ийм зүйлүүдийг тооцоолоод тэр ирээдүйд бий болох нөхцөл байдалд тааруулж өнөөдөр шийдвэрээ гаргадаг ийм зах зээлийн систем дотор бид нар үйл ажиллагаагаа явуулж байгаа. Зах зээлийн орчинд.

Тэгэхээр энэ нь өөрөө яагаад ийм учиртай вэ гэхээр зэрэг төв банкнаас гаргаж байгаа бодлогын хүүгийн шийдвэр бол өөрөө тодорхой хугацааны дараагаар эдийн засаг зах зээлд оролцож байгаа өрх, аж ахуйнууд, хөрөнгө оруулагч нар энэ бүгдийн үйл ажиллагааны шийдвэрт нь очиж нөлөөлөөд, тэр нь бодит үйл хөдлөл болоод ингээд бодит амьдрал дээр үр дүн нь гардаг. Улс орны хувьд харилцан адилгүй энэ бүрэн нөлөө гарах хугацаа өөр өөр боловч Монгол Улсын хувьд бол 4-өөс 6 улирлын дараа бүрэн нөлөө нь гардаг ийм эмпирик тооцоо судалгаанууд бий.

Инфляцын хувьд дэлхий нийтээр ер нь бол цар тахал гэдэг энэ шокийн нөлөөгөөр бол инфляц хөөрөгдсөн. Дэлхийн төв банкнуудын хүлээж байгаагаар инфляцын төсөөллүүд бол дандаа хүлээлтээс давж байгаа. Хоёр дахь нөлөөлөл нь юунаас орж ирсэн бэ гэхээр зэрэг Оросын Холбооны Улс, Украйны хооронд үүссэн нөхцөл байдалтайгаа холбоотойгоор тээврийн үнэ, эрчим хүчний үнийн хямралтай холбоотойгоор инфляцын дараагийн үеийн үр нөлөө эхэлсэн. Одоо гурав дахь нөлөө дэлхий дээр юу явж байна вэ гэхээр зэрэг хөдөлмөрийн зах зээл дээр гарч ирсэн цалин хөдөлмөрийн хөлсний үнийн өсөлттэй холбоотойгоор зардлын инфляцын ийм давлагаа бол явж байгаа.

Одоо Монголын инфляцыг бид нар дотор нь задлаад харах юм бол нэг сонирхолтой тоо бол байгаа. Монгол Улсын инфляцыг хэмждэг Үндэсний статистикийн хорооны аргачлалаар 400 бараа, бүтээгдэхүүний дунджаар инфляцыг тооцдог. Энэ 400 бараа, бүтээгдэхүүний 20 бараа, бүтээгдэхүүн нь 11.3 хувийн инфляцын 5.3-ыг нь тайлбарлаж байгаа юм. Энэ 20 бараа, бүтээгдэхүүнийг хасаад тооцвол инфляц 6 хувь гэж хэлж болно. Энэ 20 бараа, бүтээгдэхүүн дотор юу байна вэ гээд аваад үзэх юм бол 15 нь хүнсний бараа бүтээгдэхүүн байгаа юм. Үлдсэн 4-ийнх нь, үлдсэн 5-ынх нь 4 нь импортын бараа байгаа юм. Үлдсэн нэг нь хот хоорондын зорчигч тээвэр буюу тээврийн үнийг төлөөлсөн бараа явж байгаа юм.

Тэгэхээр энэ дотор юу гэж хэлж байна вэ гэхээр зэрэг энэ 20 бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамж, тогтвортой байдал энэ хүнсний асуудлыг шийдэх юм бол инфляц өнөөдөр бид нар харьцангуй бага инфляцтай байх бололцоог бүрдэж байгаа юм. Энэ харьцангуй бага инфляцтай байх бололцоо бүрдэх юм бол мөнгөний бодлого үүнд нь хариу үйлдэл үзүүлээд бодлогын хүүг зөөлрүүлэх, зээлийн хүүг бууруулах, зээлийг нэмэгдүүлэх, эдийн засгийг дэмжих ийм бололцоо орон зай

бол нээгдэхээр байгаа юм. Тэгэхээр зэрэг олон жил бид нар энэ цөөхөн хэдэн хүнсний бараа бүтээгдэхүүний ийм нөлөөлөлд бол явж ж байгаа энэ. Харамсалтай нь энэ нийлүүлэлтийн шинж чанартай, улирлын шинж чанартайгаар хэлбэлзэл нь үүсдэг энэ цөөхөн бараа бүтээгдэхүүнийг мөнгөний бодлогоор зээл санхүүжилтээр шийдэх бололцоо хязгаарлагдмал гэдэг нь бол энэ сүүлийн 20 жилийн энэ зах зээлийн энэ тогтолцооны үед бол маш тодорхой харагдаж байгаа юм.

Тэгэхээр юуг шийдэх вэ гэж. Тэгэхээр энэ дотор улирлын шинж чанарын нөлөөллийг арилгахын тулд мах, сүү, гурил гэсэн энэ бараа, бүтээгдэхүүнүүдийг ургац үйлдвэрлэл хурааж авдаг тэр үеэс нь дараагийн хомсдол үүсдэг улирлуудад нь чанарыг нь алдагдуулахгүйгээр, тогтвортойгоор, үнийн хэлбэлзэл үүсгэхгүйгээр тэр нийлүүлэлтийн, тээвэрлэлтийн, хадгалалтын ийм гинжин хэлхээг бол бодлогын түвшинд шийдэж байж энэ асуудал бол шийдэгдэх юм байна гэж бол харагдаж байгаа юм.

Товчхон дүгнээд хэлэх юм бол мах, сүү, гурил, хүнс, шатахуун гэсэн энэ бараа бүтээгдэхүүн 4, 5-хан нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн Монголын энэ 20 жилийн нийт инфляцын динамик дээр шинжилгээ хийгээд үзэх юм бол 40-50 хувийг тайлбарлаж байгаа юм. Харамсалтай нь эдгээр зүйл бол мөнгөний бодлогоос илүүтэйгээр өөр салбарын бодлогын түвшинд бол шийдэгдэх ийм асуудал байгаа гэдгийг өнөөдөр бас онцолж хэлэх нь зүйтэй байх.

**Ж.Бат-Эрдэнэ:** Доржханд гишүүн тодруулъя.

**Т.Доржханд:** За байз би А гээд асуухлаар Б гээд хариулаад байх юм. Би та нараас учир шалтгааныг нь асуугаагүй шүү дээ залуучууд аа. Ямар эдийн засгийн суурь ойлголт авах гэж энд сууж байгаа биш дээ айн. Наад

аргалдаг юмаа больчих. Тодорхой юм асуугаад байна шүү дээ. Бодлогын ямар арга хэрэгсэл хэрэглэх юм бэ. Инфляц чинь энэ өсчихлөө. Өсөх нь тодорхой байна. Зорилтот түвшиндээ хүрэхгүй юм байна. Бодлогын хүүгээ өсгөх юм уу, өсгөхгүй юм уу нэг.

Хоёрдугаарт энэ хувийн сектор чинь хумигдаад байна. Банкнууд чинь зээл гаргаж байгаа юм уу. Зээл гаргуулах юм уу, үгүй юм уу. Төв банкны үнэт цаасан дээр паркласан мөнгө чинь хэд болчихоод байгаа юм. Цаашаа хэд гэж төсөөлж байгаа юм. Ингээд төсөөллөө та нар тодорхой хэл л дээ. Тэгээд хариуцлага хүлээлгэх асуудал бол ярина. Та бүгд сайн ажиллаж байгааг би үгүй гэж бодож байна. Яагаад вэ гээд тэгэхлээр та нар яг бодитой тоонууд дээрээ бодитой зоригтойгоор дуугарахгүй. Тэгээд үр дүнд нь дандаа араас нь ингээд яваад байгаа болохлоор та нар энэ.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Хариулах юм уу. Санал хэлчэв үү. 1 дүгээр микрофон.

**Б.Баярдаваа:** Инфляцын зорилтыг Улсын Их Хурлаас төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг 2022 оны 11 сард батлахдаа 23 оны зорилтыг 1 оронтой тоо гэж бол баталсан. Энэ зорилт нь хүрнэ. 2024 онд зорилт 6+, -2 байгаа. Энэ зорилтод хүрнэ ээ 7-8 хувийн түвшинд байна гэсэн ийм төсөөлөлтэй байгаа. Бодлогын хүүг өсгөх үү, бууруулах уу гэдэг нь энэ инфляцын зорилттой уялдаж гарна. Нөгөө талаас эдийн засгийн өсөлттэй. Өнөөдрийн эдийн засгийн өсөлтийг харах юм бол 7.9 хувийн 2/3 нь уул уурхайн салбараас хамааралтай байгаа. 1/3 нь уул уурхайн бус салбар.

Тэгэхээр энэ өнөөдрийн байгаа бодлогын хүү 13 хувь гэдэг бол хангалттай өндөр. Энэ цаашаа өсөх тухай ойлголт зүгээр миний хувийн бодлоор бол байж болохгүй гэж бол харж байгаа юм. Харин орон зай үүсэх юм бол бууруулах чиглэл рүү бол

анхаарахгүй бол энэ уул уурхайн бус салбартай холбоотой бизнесүүдийн орон зай, зээлийн хүү, зээл нийлүүлэлтээр бол дамжиж хорогдоно. Үнэт цаасны үлдэгдлийн хэмжээ зээлийн өсөлтийн.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Доржханд гишүүн тодруулна. Доржханд гишүүний микрофоныг өгье.

**Т.Доржханд:** Тодорхой мэдээлэл өгөөрэй. Одоо ингээд нийлүүлэлтийн гаралтай инфляц чинь байхгүй болчихсон, эрэлтийн гаралтай инфляц бий болчихлоо гээд ингээд Засгийн газар чинь төсөв оруулж ирэхдээ яриад байгаа. Та нар энэ дээрээ санал нэг байна уу. Тэгээд зах зээл рүү мөнгө нийлүүлж байгаа төсөв чинь тэлж байгаа бол тэгээд л инфляц өснө шүү дээ. Тэгээд та нар 13 дээрээ хатуу барина гэсэн ийм популизм яриад байх юм. Үгүй ээ 13 дээрээ барих юм бол нөгөө талд ямар мөнгөний бодлогын арга хэрэгслээр энийгээ тогтоох юм бэ. Тэрийг чинь би асуугаад байна л даа. Энгийн төсөөллөөр үнэ өснө шүү дээ. Энэ чинь 7 сарын 1-нээс эхлээд 1.8 их наяд хүрч байна. Сар болгон хоёр, гурван зуун тэрбумаараа ингээд инжекшн хийгээд явна шүү дээ. Тэгээд тэр тохиолдолд та нар ямар арга хэрэгсэл ашиглах гээд байгаа юм бэ. Тэгээд яг төсөөллийг юу гэж харж байгаа юм, ханиш дээр яг барьж чадах юм уу чадахгүй юм уу. Үнэ, ханиш хоёрынхоо төсөөллийг тодорхой хэлээд, арга хэрэгслийнхээ бодлогын арга хэрэгсэлтэйгээ тодорхой хариулт өгөөдөх гэж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах юм. 1 номерын микрофон. Энэ дарга цэрэг, энэ ерөнхийлөгч нар нь өөрсдөө хариулдаггүй юм уу энэ чинь. Аль Дөлгөөн хариул даа. 3 номер.

**Г.Дөлгөөн:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Мөнгөний бодлогын хувьд бодлогын орон зай байхгүй байна. Бид бүхэн мөнгөний бодлогын хороог удахгүй хуралдуулахаар зарласан байгаа.

Энүүгээр 1 хүний шийдвэрээр биш 6 хүний шийдвэрээр гардаг учраас одоохондоо зах зээл болон санхүү дээр ямар, эдийн засаг дээр ямар нэгэн хүлээлт үүсэхгүйн тулд яг эцэслэн гаргах хариултыг хэлж мэдэхгүй байна.

Гэхдээ Мөнгөний бодлогын газраас санал оруулахдаа өнөөгийн нөхцөл байдал болон саяын таны ярьж байгаа төсвийн тодотгол мөн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж бид бүхэн шийдвэр гаргах гэж байгаа. Хамгийн гол саяын тайландаа дурдагдсан байгаа эдийн засгийг эрчимжүүлэх, ялангуяа зогсонги байдлаас гарахын үүднээс банкны зээлийг зогсоохгүй. Дээр нь нэмээд идэвхжүүлэх байдал дээр бид бүхэн маш сайн анхаарч ажиллаж байгаа гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

**Д.Батлут:** Хариулт, тодруулсан уу. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Монгол банкны 2022 оны жилийн тайланг хэлэлцэж дууслаа. Ингээд дараагийн асуудалд оръё. Ажлын хэсэгт баярлалаа. Айн цуг явчихсан байна. Дараагийн асуудалд оръё.

12.14 цаг

**Даатгалын салбарын эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсож эхэлье.**

Ажлын хэсгийг оруулъя. Ингээд даатгалын салбар болон даатгалын багц хууль хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсох гэж байна.

Та бүхэнд танилцуулга хийе. Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хүдэрчулуун Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн, Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга, Батболд Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын газрын дарга, Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын

Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Жавхлан “Үндэсний давхар даатгал” компанийн захирал, Батбаяр Бизнес хөгжлийн төслийн газрын дарга, Жавхланцог Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн зөвлөх, Батцэцэг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын ахлах референт гэсэн ийм хүмүүс оролцож байна.

Ингээд эхний танилцуулгыг Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Сонор хийнэ. Сонор даргын микрофоныг нээе.

**Л.Сонор:** Эдийн засгийн байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Сангийн яамны зүгээс даатгалын салбарын түүхэн замнал, өнөөгийн нөхцөл байдал болон хууль, эрх зүйн хүрээнд хийгдэж буй шинэчлэлийн талаар мэдээллийг өгье.

Даатгалын салбарын хувьд Монгол Улсад бол 1934 онд Улсыг аюулаас хамгаалах газар анх байгуулагдсанаар даатгалын салбарын үүсэл хөгжил эхэлсэн байдаг. Улмаар бол 1997 онд Даатгалын тухай хууль батлагдаж, улмаар 2004 онд Даатгалын хууль шинэчлэгдэн даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль шинээр батлагдсан байдаг.

Улмаар 2006 онд Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсанаар даатгалын салбарын зохицуулалтын орчин хяналт шалгалтыг Санхүүгийн зохицуулах хороо хийж эхэлсэн бөгөөд 2008 оноос анхны урт хугацааны даатгалын компани буюу National life байгуулагдсанаар амьдралын даатгалын үйлчилгээ эхэлсэн байгаа.

2011 онд Жолоочийн даатгалын тухай хууль, 2014 онд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулиуд

батлагдсан. 2005-2015 оны хооронд Дэлхийн банкны малын индексжүүлсэн даатгалын төсөл амжилттай хэрэгжиж улмаар бол хөдөө аж ахуйн “Давхар даатгал” компани энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байгаа.

2018 онд Үндэсний хөдөө аж ахуйн “Давхар даатгал” компани маань “Үндэсний давхар даатгал” компани болж үйл ажиллагаагаа тэлж, одоо энэ жил бол анх “Үндэсний давхар даатгал” компани бол IPO хийж олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох бүх бэлтгэл ажлаа хийгээд энэ жилдээ багтааж хувьцаагаа гаргахаар ажиллаж байна.

Одоогийн яг одоо бол тусгай зөвшөөрөлтэйгөөр даатгалын нийт 18 компани үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс бол ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 2 компани, давхар даатгалын 1 компани, мөн даатгалын хохирол үнэлэгч 25 ширхэг байна. Даатгалын зуучлагч 6. Үүнээс бол банк зуучлагч 10 банк болон зуучлалын үйл ажиллагааг эрхэлж байгаа.

Санхүүгийн салбарын нийт бүтцээр нь аваад үзэх юм бол даатгалын салбар бол нийт санхүүгийн салбарын 1 хувийг эзэлж байгаа. Манай улсын хувьд бол 90 оноос хойш банкны салбар давамгайлсан санхүүгийн салбарын бүтэцтэй явж байсан ирсэн бол сүүлийн энэ жилүүдэд хөрөнгийн зах зээл маань хурдацтай тэлж. Гэсэн хэдий ч санхүүгийн салбарын гурван тулгуур баганын нэг болох даатгалын салбар бол өнөөг хүртэл 1 хувь буюу маш бага хувийг эзэлсээр байна. Олон улсын хувьд бусад орнуудтай харьцуулахад Монгол Улс маань ямар, ямар байгаа вэ гэх юм бол даатгалын салбарын хөгжлийг 4 үе шатад хувааж авч үздэг. Нуугдмал үе, өсөлтийн эхэн үе, тогтвортой өсөлтийн үе, гүйцэд хөгжсөн үе.

Монгол улсын хувьд бол Египет зэрэг орнуудтай хамт өсөлтийн эхэн

үедээ явж байна гэж үздэг. Тэгээд даатгалын салбарын олон улсад даатгалын салбарын гол 2 үзүүлэлтээр хэмждэг энэхүү 2 үзүүлэлт бол даатгалын гүнзгийрэлт буюу даатгалын нийт салбарын хураамжийн орлогыг дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан харьцаа байдаг. Энэ нь Монгол Улсын хувьд 2022 оны эцсийн байдлаар 0.63 хувь байгаа. Энэ нь дэлхийн дундажтай харьцуулахад 10 дахин бага гэсэн үзүүлэлт байгаа. Дэлхийн дундаж нь 6.8 хувь байгаа. Даатгалын нягтралын хувьд бол 2022 оны эцсийн, жилийн эцсийн байдлаар ам.долларт хөрвүүлэх юм бол 30 доллар байгаа. Энэ нь мөн ялгаагүй дэлхийн дунджаасаа маш бага буюу дэлхийн дундаж нь 853 доллар байдаг. Энэ нь бол юуг илэрхийлж байна вэ гэвэл Монгол Улсын хувьд даатгалын салбарын хөгжил бол бас нэлээн эхэн шатдаа явж байна. Даатгалын салбарын үндсэн үзүүлэлт бол сүүлийн 10 жилд өсөж байгаа. 22 оны эцэст бол даатгалын компаниудын нийт хөрөнгө 475 тэрбум болж өссөн. Даатгалын салбарын нийт хураамжийн орлого нь 305 тэрбум төгрөг болж нэмэгдсэн байгаа. Мөн давхар даатгалын хураамж өнгөрсөн онд 99 тэрбум байсан бол давхар даатгалын хураамжийн үлдэлтийн харьцаа буюу recession rate нь 66.8 хувь болсон байна.

Даатгалын салбарын хувьд хууль, эрх зүйн шинэчлэлийг хийхээр Засгийн газар болон санхүү Санхүүгийн зохицуулах хороо ажиллаж байна. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр мөн Монгол Улсын хууль тогтоомжийг 24 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд даатгалын салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийг хийх заалтууд туссан байгаа. Жишээ нь “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогод давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, даатгалын зах зээлийн тогтвортой

байдлыг хангах зэрэг заалтууд орсон байдаг.

Мөн энэ Монгол Улсын хууль тогтоомжийг 24 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэж мэргэжлийн оролцогчийн тухай хууль, мөн Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал бол орсон. Үүнтэй холбоотойгоор энэхүү 3 хуулийг багцлаад даатгалын багц хуулийн шинэчлэлийн төслийг Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран боловсруулаад өргөн мэдүүлэхэд бол бэлдэж байна. Энэхүү хууль, эрх зүйн шинэчлэлээр дараах тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж байгаа.

Нэгдүгээрт бол технологийн одоогийн хууль, эрх зүйн хүрээнд технологийн шийдлийг ашиглах боломж хомс байдаг.

Хоёрдугаарт нь амьдралын даатгалын хөгжил сул.

Гуравт хамтын даатгалын зохицуулалт байхгүй.

Дөрөвт нь бол засаглал давхар даатгалын зохицуулалтыг бас боловсронгуй болгох шаардлага байгаа.

Тавдугаарт даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Мөн зургаадугаарт заавал даатгалын дэд бүтцийг боловсронгуй болгох, хуулиудын хэрэгжилтийг хангах дараах тулгамдсан асуудлууд байгаа гэж байгаа тул эдгээр асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор энэхүү даатгалын багц хуулийн төслийг боловсруулаад ойрын хугацаанд бол Засгийн газрын хуралдаанд танилцуулж, улмаар Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Ерөнхий мэдээллийг Сангийн яамнаас өгч дуусгалаа.

**Д.Батлут:** Сонор даргад баярлалаа. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Баярсайхан дарга дараагийн танилцуулгыг хийнэ Баярсайхан даргын микрофоныг нээе. 3 номерын микрофон.

**Д.Баярсайхан:** Эдийн засгийн байнгын хорооны хурал даргалагч болон гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрвье.

Ерөнхийдөө бас мэдээллүүд нэлээн давхцаж байна. Тэгэхээр давхцаагүй мэдээллийг өгье. Түүрхэн хэллээ Санхүүгийн зохицуулах хорооны хяналт зохицуулалтад байгаа тусгай зөвшөөрөл бүхий 3 төрлийн даатгалын компаниуд үйл ажиллагаа явуулж байна. Ердийн даатгалын 15 компани байна, урт хугацааны 2 компанийн үйл ажиллагаа явж байна. Үндэсний хэмжээнд Үндэсний давхар даатгал гээд давхар даатгалын 1 компани Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрлөө аваад үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

Дээрээс нь энэ даатгалын салбарт эдгээр компаниас гадна даатгалын зуучлагч компаниуд, даатгалын хохирол үнэлэгч, даатгалын төлөөлөгч Актурч аудитын компани зэрэг тусгай зөвшөөрөл эрх бүхий этгээдүүд үйл ажиллагаагаа явуулдаг гэдгийг хэлэх нь зөв байх. Өнөөдрийн байдлаар 1.3 сая даатгуулагч иргэд байна. 688 даатгалын бүтээгдэхүүн бол Монгол Улсын даатгалын зах зээл дээр өнөөдрийн байдлаар байна гэдгийг хэлье.

Ер нь даатгалын зах зээл зайлиггүй цаашидаа энэ санхүүгийн салбарын тулганы гурван чулуугийн хувьд гурван чулуу бүрдүүлж байгаа нэг хэсгийн хувьд өсөх шаардлагатай байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний өнгөрсөн оны эцсээр харьцуулж үзэхэд бол 10-хан хувьтай байна. 216.9 тэрбум төгрөгийн нөөц сантай. Өөрийн хөрөнгө нь өнгөрсөн оны мөн үеэс 11.6 хувийн өсөлт

үзүүлээд 474.9 тэрбум төгрөгийн энэ даатгалын компаниудын нийт хөрөнгө үнэлэгдэж байна.

Хэдийгээр энэ дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь багас байгаа ч гэсэн сүүлийн 2020 оноос хойш харах юм бол 4.4, 11.3, 11.6 гэдэг ийм хувь хэмжээгээр харьцангуй бас өсөлтийг үзүүлж байгаа гэдгийг дурдах нь зөв байх. Тэгээд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийтдээ 484.8 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын эрсдэлийг хүлээж авч байгаа.

Даатгалын нийт хураамжийн орлого бол өмнөх оноос бас өсөлттэй буюу 23.5 хувиар өссөн байна. 300 тэрбум төгрөгийн даатгалын нийт хураамжийн орлоготой ажилласан бөгөөд үүнээс давхар даатгалын хураамжийн зардал 100 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна. Ер нь бас даатгалын салбарт энэ бодлого боловсруулагч хяналт зохицуулалтын зүгээс ялангуяа энэ даатгалын хураамжаар орж байгаа орлогыг давхар даатгалд бас 1/3 орчим хувийн энэ гадагшийг гаргадаг. Энийгээ дотооддоо үлдээх ийм бодлого баримталж байгаа. Энэ хүрээндээ ч гэсэн Малын индекс үзүүлсэн даатгал гээд энэ компанийг өргөжүүлээд Үндэсний давхар даатгалын компани бий болсон. Цаашдаа ч гэсэн энэ салбарын бодлого боловсруулагчид болон хяналт зохицуулалтын байгууллагууд энийгээ бас илүү чадавхжуулах тал дээр онцгой анхаарч байгаа гэдгийг бас хэлэх нь зөв байх.

Хураамжийн орлогыг бас бүтцээр нь аваад задлаад харчих нь зөв байх. Нийт хураамжийн орлогынхоо 33.5 хувийг давхар даатгалын хураамжийн зардал, 1/3 хувь нь хураамжийн буцаалт, 10.3 хувь нь даатгалын гэрээний зардал, 4.8 хувь нь нөөцийн сан, 26.2 хувь нь нөхөн төлбөрийн цэвэр зардал, 15.8 нь үйл ажиллагааны зардал буюу эцэст нь 6.3 хувь нь даатгалын үйл ажиллагааны ашиг гэсэн ийм статистик мэдээлэл

байгааг би хэлчих нь зөв байх гэж бодож байна.

Ер нь түрүүн бас хэлсэн олон улсын жишигтэй харьцуулахад бас 2 статистикийг нэлээн анхаарч үзээд байгаа юм. Даатгалын нягтрал буюу даатгалын гүнзгийрэлт гэсэн ойлголт байдаг. Даатгалын нягтрал буюу 1 хүнд ноогдох хураамжийн орлогын харьцаа 2022 оны жилийн эцсийн байдлаар ам.долларт шилжүүлбэл 25.4 долларт байгаад байгаа.

Гэтэл олон улсад бол ер нь 900 орчим ийм дүнтэй байдаг. Тэгэхээр ямар орон зай байгаа нь харагдаж байгаа. Дээрээс нь даатгалын гүнзгийрэлт буюу дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх даатгалын хураамжийн орлогын хувь хэмжээ бол өнгөрсөн оны эцсээр 0.63 хувьтай байж байна. Энэ нь бас л олон улсын жишигтэй харьцуулахад бас маш бага хувь хэмжээтэй байгаад байгаа. Тэгэхээр ялангуяа энэ даатгалын зах зээлийг энэ санхүүгийн салбарт эзлэх хувь хэмжээг өсгөх тэр хэрээр энэ салбарын эрсдэлийг даахад онцгой ач холбогдол ч өгөх шаардлагатай байгаа. Энэ хүрээндээ ч гэсэн Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яамтай хамтраад бусад холбогдох газруудаас саналыг нь аваад энэ даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга хэлбэрээр төслийг нь бэлдчихсэн Засгийн газрын яамдаас саналаа аваад дуусчихсан байгаа. Мөдхөн бас өргөн барих байх гэсэн ийм хүлээлттэй ажиллаж байна гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Тэгээд бас 1 онцлог үзүүлэлт байгаад байгаа. Ер нь ердийн даатгал, урт хугацааны даатгалыг харьцангуй хөгжилтэй орнуудад харьцаа хэд байдаг вэ гэдэг дээр 45, 55 ч юм уу 40, 60 гэсэн ийм харьцаатай байдаг юм байна лээ олон улсын зах зээл дээр. Монголд бол 99, 1 гэсэн тийм ийм харьцаатай байгаад байгаа.

Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хураамж, нөхөн төлбөрийн



хувь хэмжээг бас танилцуулчих нь зөв байх. Даатгалын 16 хэлбэрийн ийм бүтээгдэхүүн үйлчилгээ байгаад байгаа. Хураамжийнх нь хувьд бол хамгийн өндөр дүнтэй гэж үзэх юм бол энэ хөрөнгийн даатгал 24 хувь, тэгээд авто тээврийн хэрэгслийн даатгал 22.3, тэгээд мэргэжлийн хариуцлагын болон гадаад зорчигчийн, газар тариалан, санхүүгийн, агаарын хөлгийн даатгалууд нийлээд 24.2 хувьтай, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 13.7 хувьтай байна.

Нөгөө талд нь нөхөн төлбөр бол ямар байдлаар олгогддог вэ гэх юм бол жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 34.4 хувийг нөхөн төлбөр хэлбэрээр олгогддог байна. Авто тээврийн хэрэгслийн даатгал 28.8 хувь буюу нийтдээ 63.2 хувийн энэ даатгалын нөхөн төлбөрөөр өндөр дүнтэйгээр олгогддог гэдгийг хэлэх нь зөв байна.

Нийт хураамжийн хувьд бол энэ жолоочийн хариуцлагын даатгал дээр бас нэлээдгүй асуулт гараад байдаг. Энэ дээр 40.9 тэрбум төгрөг бол дүнгээрээ хураагдаж байгаа. Гэтэл нөгөө талд нь нөхөн төлбөр байдлаар 31.9 тэрбум төгрөг олгогдсон байна. Энэ нь олон улсын дунджаас харьцангуй өндөр дүнтэй байдаг гэдгийг манай салбарынхан хэлдэг.

Өнөөдрийн бас асуудал дээр бас онцгой бас ач холбогдол өгч асуусан 1 асуулт нь ер нь энэ малын индексжүүлсэн даатгалын нөхцөл байдалтай холбоотой ерөнхий хэдэн статистикийг хэлье гэж бодож байна.

Малын индексжүүлсэн даатгалын хувьд ер нь малын индексжүүлсэн даатгал нь тухайн сумын хэмжээнд гарсан малын хорогдлыг хувиар босго үзүүлэлт буюу индекс тогтоож түүнээс давсан хувиар мал хорогдсон тохиолдолд тухайн сумын малаа даатгуулсан даатгуулагчдад нөхөн төлбөр олгодог ийм даатгалын систем байгаа.

Анх Монгол Улсад Дэлхийн банкны санхүүжилтээр Тогтвортой амьжиргаа 1 төслийн хүрээнд ер нь энэ Вьетнамын газар тариалангийн даатгалд индексжүүлсэн даатгалаар үндэслэж Дэлхийн банкны экспертүүд судалгааг нь хийгээд Монголд нутагишуулаад хэрэгжүүлсэн юм байна лээ. Үүнээс хойш бас нэлээдгүй хугацаа өнгөрчихлөө. Тэгээд тус даатгалд даатгуулсан малчид нь ган, зуд зэрэг байгаль цаг уурын эрс тэс нөхцөлөөс үүдэлтэй ихээхэн хэмжээний хохирол учирсан тохиолдолд нөхөн төлбөр авах боломжтой байдаг бөгөөд эрсдэлийн түвшний босго үзүүлэлтийг Засгийн газар тогтоодог.

Засгийн газрын хувьд хамгийн сүүлд 2020 оны 219 дүгээр тогтоолоор 1 дүгээр босго үзүүлэлтийг 5-6 хувь, 2 дугаар босго үзүүлэлтийг 25-30 хувиар тогтоосон юм байна лээ. Тэгээд энэ 1 дүгээр босго үзүүлэлт, 2 дугаар босго үзүүлэлт гэдэг нь тухайн сумын хэмжээнд нийт хоргодол үзүүлсэн тэр хэмжээгээ хэлээд байгаа юм байна лээ. Хэрвээ 5-аас, зүүн бүсүүдэд 5 хувь малын хоргодол, баруун бүсэд босго үзүүлэлтийн 6 хувь гэсэн юм байна лээ. Энэ хүртэл бол ямар нэгэн байдлаар хохирол амссан эсэхээс үл хамаараад малын индексжүүлсэнд даатгал тухайн сумын малчин бүр нөхөн төлбөр авах бол сумын хэмжээнд гарсан малын хорогдол босго үзүүлэлт хүргэхгүй тохиолдолд нөхөн төлбөр олгогддоггүй хэлбэрээр ийм зохицуулалттай байгаа юм байна лээ.

Тэгээд биднүүс бас нэг статистик нь энэ 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт малчин өрхийн 14.4 хувь, нийт малын тоо толгойны 8 орчим хувь нь малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан. Өөрөөр хэлбэл энэ даатгалд хамрагдалт их бага хувьтай байгаад байна. Дээрээс нь 117.9 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий малыг даатгаж 3.9 тэрбумын даатгалын хураамжийг төвлөрүүлсэн байна гэж байгаа юм. Энэ хохирлыг хэзээ үнэлдэг вэ гэхээр жилд 2 удаа улс даяар малын тоол хийдэг. Энэ хагас жилээр хийгдэх ёстой. 5 сарын

сүүлийн 7 хоногоос 6 сарын эхний 7 хоногийн хугацаанд хагас жилийн тооллого хийгдэнэ. Энэ тооллого нь хийгдсэний дараа нэгтгэл хийгдээд үнэхээр малын хорогдол тэр босго оноогоо, босгоод авсан нөхцөлд малчдад нөхөн төлбөр малын индексжүүлсэн даатгал компаниас олгоно. Үндэсний давхар даатгал компаниас олгогдохоор байгаа юм байна лээ.

Зүгээр урьдчилсан байдлаар тооцоолол хийгээд үзэхэд манай энэ Үндэсний давхар даатгалын компанийнхны хэлж байгаагаар ер нь энэ жил бас урьд жилүүдийг харьцуулахад харьцангуй өндөр нөхөн төлбөр олгогдохоор байгаа. Энэ процесс нь явсаар байгаад ер нь яг иргэддээ малчдад 8 сарын сүүл, 9 сар гэхэд хохирлын нөхөн төлбөр олгогдохоор байгаа гэсэн танилцуулгыг хийж байгаа гэдгийг хэлье. Тэгээд цаашидаа мэдээж энэ малын индексжүүлсэн даатгалын энэ бүтээгдэхүүнийг илүү сайжруулах төгс болгох тал дээр бас онцгой анхаарч ажиллах шаардлага байгаад байгаа гэдгийг бас хэлэх нь зөв байх.

Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр яг энэ үед зэрэгцээд асуулга тавьчихсан. Тэн дээр энэ Үндэсний давхар даатгалын компанийн гүйцэтгэх захирал Жавхлан энд оролцож байгаа. Энэ компанийнх нь төлөөлөл бас энд сууж байгаа. Бас өшөө тодруулах зүйлс байвал нэмээд хариулаад явах байх гэж бодож байна.

Малын индексжүүлсэн даатгалын энэ бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой бас малчны төлсөн хураамжийн хэмжээ болон олгосон нөхөн төлбөрийн хэмжээг хохирлын харьцаатайгаа бас сүүлийн хэдэн жилийн графикийг нь харьцуулаад харах юм бол малчны төлсөн хураамжийн харьцаа бас жил өсөх тусам бас харьцангуй бага зэрэг өсөлттэй байгаа. Гэхдээ нөгөө талаар олгосон нөхөн төлбөрийн хэмжээ, жил бол харьцангуй өндөр тэгээд нэг буудаг. Тухайн жил хэр

хүнд жил байснаасаа хамаардаг юм байна лээ. Зүгээр 2 тоо хэлчихье гэж бодож байна. 2019 онд малчны төлсөн хураамжийн хэмжээ 3.8 тэрбум төгрөг олгогдож байсан бол нөхөн төлбөрт 600 сая төгрөг олгосон байгаа юм.

Гэтэл 20 онд малчны төлсөн хураамжийн хэмжээ 3.5 тэрбум төлсөн мөртөө энэ олгосон нөхөн төлбөрийн хэмжээ нь 2.6 тэрбум төгрөгийг олгосон хэмжээтэй байж байна. Гэтэл 2021 онд ерөөсөө энэ харьцангуй сайхан өвөл болсонтой холбоотой. Энэ олгосон нөхөн төлбөрийн хэмжээ маш бага. Зүгээр малчны төлсөн хураамжийн хэмжээ 3.9 тэрбум төгрөг хураамжийн олгогдсон хураагдсан байгаа.

2022 оны байдлаар хураамжийн хэмжээ 3.9 тэрбум төгрөг хүрчих байх. Гэхдээ нөхөн төлбөрт бас энэ дүнгийн бараг 70 орчим хувьд бас олгогдох болов уу гэсэн ийм тооцоололтой байгаа юм байна лээ.

Ер нь түрүүн бас Сангийн яамны төлөөлөл Сонор дарга дарга бас товчхон хэлсэн. Даатгалын салбар дээр бас онцгой анхаарч байгаа. Тэгээд энэ даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр шинэчилсэн найруулга хэлбэрээр бэлдсэн байгаа. Гол агуулгууд нь гэх юм бол юу гэдэг юм заавал даатгалын нэр төрлийг олируулах, амьдралд илүү хэрэгжүүлэх шаардлага үүсчхээд байгаа юм. Өөрөөр хэлбэл заавал даатгалын нэгдсэн зохицуулалтын орчныг зайлшгүй бий болгохгүй бол яг өнөөдрийн хууль тогтоомжийн хүрээнд харах юм бол салбарын зохицуулалтын хуулиуд дээр байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ барилга, нотариат, шүүгч, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль гээд энэ чинь орчин тойрондоо эрсдэл үүсэж болзошгүй энэ ажил, мэргэжлүүдэд ийм зайлшгүй даатгалтай бай гээд заачихсан. 18 төрлийн хууль тогтоомж нь байдаг хэдий ч яг амьдрал дээр хэрэгжилт маш муутай.

Үүнийг биднүүс томьёолохдоо тухайн салбарын яамтай хамтраад Санхүүгийн зохицуулах хороо бол нарийвчилсан журмаар зохицуулалтыг нь хэрэгжилтийг хангуулна гэж тусгуулж байгаа. Өөрөөр хэлбэл заавал даатгалын нэр төрлийг амьдрал дээр заавал хэрэгжүүлдэг, энд нь хэрэгжилттэй нь холбоотой хяналт тавьдаг ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа.

Дээрээс нь бас дундын зуучлалын буюу энэ даатгалын зуучлалын үйл ажиллагааг илүү мэргэшүүлж, төлөвшүүлэх дээр бас онцгой анхаарал тавьж ажиллаж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

Ер нь бас даатгалын компаниуд маань бас сүүлийн жилүүдэд гарсан нэг ахиц дэвшил нь гэх юм бол олон нийтийн компани болчихсон байгаа. 4 даатгалын нөгөө ярьж байгаа биднүүсийн 18 даатгалын тусгай зөвшөөрөлтэй этгээд байгаа шүү дээ 4 даатгалын компани бол хуучнаар 5-10 тийм эзэнтэй байсан бол өнөөдрийн байдлаар нийт 21855 хувьцаа эзэмшигчтэй болчихсон. Өөрөөр хэлбэл IPO хийх байдлаар олон нийтэд хувьцаагаа санал болгоод ингээд амжилттай бас үйл ажиллагаа явуулж байгаа гэдгийг хэлмээр байна.

Нөгөө талаас хөрөнгийн зах зээлийн бас үндсэн гол тоглогчид энэ даатгалын салбарын даатгалын сангууд, нөөцийн сангууд байдаг.х Хорооноос бол энэ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тавьж өгдөг байгаа. Өнгөрсөн оны хувьд энэ шалгуур үзүүлэлтийг 10 хувь буулгаснаар хөрөнгийн зах зээл дээр оролцох энэ боломж нь бол нээгдсэн. Өөрөөр хэлбэл 183 тэрбум төгрөг хөрөнгийн зах зээл дээр орох ийм бололцоог нээсэн гэдгийг бас хэлэх нь зөв байх. Яг өнгөрсөн оны эцсээр компанийн өргөн хэрэгсэлд 50.7 тэрбум төгрөг, Монголын хөрөнгийн биржийн нэгдүгээр ангиллын хувьцаанд 11 орчим тэрбум төгрөг, хоёрдугаар ангиллын хувьцаанд 3 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт байна.

Цаашидаа бол мэдээж энэ даатгалын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээг хууль, эрх зүйн зохицуулалтаас гадна бас онцлог үйл явдлууд тохиолдож байгаа. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн болон нэр бүхий гишүүд энэ даатгагчийн баталгааны тухай хуулийг дагуулаад Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Өөрөөр хэлбэл энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж оролцоходоо банкны баталгаа биш даатгагчийн баталгааг гаргаад оролцох ийм боломжийг нээсэн. Энэтэй холбоотой ч гэсэн даатгалын бүтээгдэхүүнүүд гараад амжилттай юу гэдэг юм энэ тендерт оролцоод энэ үйл ажиллагааны нэг хэсэг болоод явж байгаа гэдэг биднүүст мэдээлэл ирсэн байгаа.

Ингээд хорооны даатгалын салбар дээр хийгдэж байгаа ажлууд, цаашид хийгдэх энэ тодорхой зорилтуудын хүрээнд товч танилцуулгыг энэ хүргээд өндөрлөе.

Анхаарал тавьсан гишүүд баярлалаа.

**Д.Батлут:** Танилцуулга, мэдээлэл явагдаад дууслаа. Ингээд танилцуулга, мэдээлэлтэй холбоотой асуулт асууж үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Доржханд гишүүнээр тасалъя. Ганибал гишүүн асуултаа асууя.

**Н.Ганибал:** Санхүүгийн зохицуулан хорооны мэдээлэлд бас баярлалаа. Сангийн яамныхан бас ирчихсэн байна. Ер нь даатгалын салбарын зайлиггүй нэг шинэчлэлийн асуудал бол бидний өмнө тулгарсан. Аль аль асуудлууд нь. Энэ дээр бид нарын хувьд бол хуучин гаргасан хуулиуд маань цаг хугацааныхаа хувьд бас өөрчлөгдөж зайлиггүй шаардлагууд бас харагдаад байх шиг байгаа юм. Энд эрсдэлийнх нь хувьд тодорхой хэмжээнд зарим асуудлууд нь буурч байгаа байх,

зарим нь нэмэгдэж байгаа байх. Санхүүгийн боломжууд бас Монгол Улсын хэмжээнд компаниудын хувьд бас илүү боломжууд бас гарч ирсэн гээд ингээд нөхцөл байдлууд дээр дүгнэлт хийгээд, даатгалын салбартаа бид нар зайлиггүй шинэчлэл хийх шаардлагатай байна. Энэ дотроос яагаад малын индексжүүлсэн даатгалын асуудлыг ярьсан юм бэ гэхээр Монгол Улсын хэмжээнд энэ жилийн хувьд хамгийн хүнд жил боллоо мал аж ахуйн салбарт. Өвөл -45, 40 градус хүрсэн ийм он, өвөл боллоо. Хавар нөгөө дулаарч өгөхгүй бүтэн 3 сар хавсаргатай ийм цаг хугацаа.

Дээрээс нь зуны эхэн сарын, эхэн сард цасан шуурга шуурч бас энэ зүүн аймгуудад маш хүнд гарз хохирол болсон ийм жил боллоо. Гэхдээ гарч байгаа хорогдол бол харьцангуй юу гэдэг юм 80-аад оны үед 2000 оны үе, 2010-аад оны үеийнхнээр энэ бол гарз хохирол нь харьцангуй бага байгаа юм. Яагаад гэхээрээ Монголын мал аж ахуйн бэлчээрийн мал аж ахуйд тэр өөрсдийнхөө эрсдэлийг авч гарах тэр чадамж нь арай дээрдсэн л дээ.

Гэхдээ гарч байгаа нөхцөл байдлуудыг бол бид нар Монголчууд бүгдээрээ харж байна. Малын тоо толгой үүссэн, бэлчээр доройтсон, энэ цаг уурын бас өөрчлөлтүүд гээд. Тэгээд энэ болгон дээр хөдөө аж ахуйн салбар Хөдөө аж ахуйн яам бас бодлогоо гаргаад Сангийн яамтай ингэж зохицож явдаг л даа. Тэгээд тэр дээр хяналтыг нь мэдээж Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжилт, хяналтыг нь тавьж. Энэ яагаад энэ эрсдэлээс өнөөдөр яагаад энийг яриад байна вэ гэхээрээ өнөөдрийн малын индексжүүлсэн даатгал бол бодит амьдрал дээр хэрэгжихээ больчихлоо л гэж байгаа юм. Хэрэгжихээ больж байна. Энэ өнөөдөр харагдаад байгаа юм.

Тэгэхээр энэ шиг ийм он жилүүд их олон тохиохгүй байх л даа. Зүгээр хамгийн эрсдэлтэй энэ он жил дээр энэ

малын индексжүүлсэн даатгал маань хэрхэн ажиллах вэ гэдэг бас ингээд эргэлзээтэй байгаа юм.

Хоёрт нь хуучин Дэлхийн банкны төсөл байхдаа маш сайн сурталчилгаанууд хийгддэг байсан. Мал аж ахуйн малчид энэ даатгалаа хамрагдах тал дээр. Одоо төрийн компани болчихсон чинь зөвхөн тодорхой хэмжээнд жоохон хураамж аваад тэгээд тэр дээр хандчихдаг юм уу сурталчилгаа нь багасчихсан. Уг нь бид нарын үндсэн үүрэг бол сайн дурын даатгал дээр маш их сурталчилгаа хийгээд тэгээд түүнийхээ үр дүнд орлогоо хуримтлуулаад цаашаа энэ үйл ажиллагаа явах ёстой л доо. Тэгээд энэ хэдэн ажлууд ингээд орхигдоод байна. Энийг хэдүүлээ бүх талын оролцогч нар байгаа учраас энийг шинэчлэх, өөрчлөх тэгээд малчдад маань үр дүнтэй ийм даатгал болоосой л гэж хүсэж байгаа юм.

Ер нь яагаад эрсдэл багассан бэ гэхээр өнөөдөр Монгол Улсад уул уурхай нэлээдгүй хөгжсөн. Тэгээд хүнд техникүүд Монголын аль ч аймагт бий болчихсон. Ямар нэгэн цасанд зам хаагдана гэдэг ойлголт байхгүй болчихсон байхгүй юу. Цаашилаад малын тэжээлийн асуудлуудыг малчид хэрэглээд эхэлчихсэн. Тодорхой хэмжээнд өвс, хадлан тэжээлээ бэлддэг болоод эхэлчихсэн гээд тэгээд энэ нөхцөл байдлуудыг бид нар эргэж харж, ярилцаж энэ асуудлаа гаргаж ирэх нь зөв байх л гэсэн ийм л саналтай байгаа.

**Д.Батлут:** Уг хэлчэв үү тээ. Тийм санал хэлчихлээ. Хариулах хүмүүс байна уу. 2 асуудал дээр нэлээн тодорхой байр суурь илэрхийлчихлээ шүү дээ. Даатгалын компаниудын, энэ даатгалын энэ хуультай холбоотой, шинэчлэлтэй холбоотой асуудал байна. Хоёрт нь Дэлхийн банкны төсөл хэрэгжиж байх үед мэдээ, мэдээлэл нэлээн сайн хүрдэг байсан. Одоо төрийн байгууллага болсноороо мэдээлэл, сурталчилгааны асуудлууд нэлээн алга болчихлоо. Ер нь

мал аж ахуй зөнгөөрөө явж байна гэдэг санаа гаргаж байна. Хариултаа хэлчээд дараа нь тодруулна. 3 номерын микрофон нээе.

**Д.Баярсайхан:** Улсын Их Хурал, Засгийн газраас төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийг олон нийтийн компани болгох Монголын хөрөнгийн биржээр дамжуулах энэ үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх гээд энэ тогтоолын хүрээнд 25 аж ахуйн нэгж 34 хувь хүртэлх хувийг IPO хийх замаар олон нийтийн болго гээд. Энэ жагсаалтад бол малын Үндэсний давхар даатгалын компани байгаа. Энэ хүрээндээ бэлтгэлээ хангаад Санхүүгийн зохицуулах хорооноосоо зөвшөөрлөө авсан байгаа.

Тэгээд 20 хувиа олон нийтэд санал болгохоор бэлтгэлээ хангаад явж байгаа. Намраас энэ олон нийтээс санхүүжилт татах үйл ажиллагаа нь хийгдэх байх. Энэнтэй холбоотой бас юу гэдэг юм бэлтгэл ажил давхацсан байх. Нөгөөтээгүүр юу гэдэг юм энэ Төсвийн хэмнэлтийн хууль, төр, хувийн хэвшил гэлтгүй төр дотроо төрийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдэд бас хэрэгжсэн энэтэй холбоотой яг тэр сурталчилгааны зардлууд бас тодорхой хумигдсан гэсэн мэдээлэлтэй байгаа.

Гэхдээ үндсэн үйл ажиллагаа нь учраас эднүүсийн хувьд зайлиггүй зарцуулаад явах байх. Компанийн төлөөлөл нь илүү нарийн мэдээлэл өгөх байх. Тэгээд энэ хуулийн, даатгалын багц хуулийн хүрээнд зайлиггүй биднүүс сайжруулаад аваад явна. Зүгээр малын индексжүүлсэн даатгал бол тусдаа тусдаа хуультай байгаа. Энэ тал дээр бол Сангийн яам бас бусад оролцогч талуудтай хамтраад бас ярилцах зайлиггүй ийм орон зай шаардлага байгаа гэдгийг ойлгож байгаа. Зохицуулагчийн зүгээс.

**Д.Батлут:** Өөр нэмэлт хариулттай хүн байгаа юу. Тэр 2 номер дээр шилжээд суучих. 1 дээр шилжээд

суучих. 1 номерын микрофоныг нээе. Өөрийгөө танилцуулаад яваарай.

**Б.Батбаяр:** Сайн байна уу. Намайг Батбаяр гэдэг Үндэсний давхар даатгал хувьцаат компанийн Андеррайтинг бизнес хөгжлийн газрын дарга байна. Хоёр асуултад хариулт өгье.

Энэ жилийн өвөлжилтийн байдлаар бас тодорхой зүүн бүсийн аймгуудад, зүүн бүсийн аймгуудад бас малын даатгалаар бас хорогдол гаргах таамаглал байгаа. Яг түрүүн Баяраа Баярсайхан даргын хэлсний дагуу Улсын Статистикийн хорооноос хагас жилийн малын тооллого гарахлаар бид нар яг бодит үнэн статистикийн мэдээлэлдээ тулгуурласан тоог олон нийтэд зарлах тул ерөнхийдөө хохирол гарах төлөв байна. Нийт Хэнтий аймгийн 6 сум, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, 6 сумд хохирол гарах магадлалтай байгаа гэж хэлж байна.

Мөн зар сурталчилгааны тал дээр хэлэхэд бид үндсэн үйл ажиллагаа маань давхар даатгалын үйл ажиллагаа, даатгалын багц хуулийнхаа дагуу бид яг иргэдийн энэ индексжүүлсэн даатгалын компанийг малын даатгалын хэлбэрээр тусгай зөвшөөрөл авсан компаниудаар дамжуулан иргэдэд хүргэдэг. Тухайн компаниуд малчдад тухайн бүтээгдэхүүний танилцуулгыг хийж, сошиал болон сурталчилгааг орон нутгийн телевиз гэх мэт зүйлээр хийж яваа.

**Д.Батлут:** Баярлалаа. Доржханд гишүүнд асуулт асууя.

**Т.Доржханд:** Баярлалаа. Би энэ мөнгөний бодлого, тэгээд энэ төв банкны үйл ажиллагаанд нэлээн шүүмжлэлттэй хандаж байгаа. Харин энэ Зохицуулах хорооны ажлын хувьд бас урагш байна гэж хардаг. Боломжийн ажиллаж байгаа. Гэхдээ асуудал бол байна гээд. Тэр асуудал нь орж ирж байна. Энэ бол даатгалын салбар байдаг. Тэгээд би

өөрөө бас Сангийн яаманд яг энэ асуудлыг хариуцаж байсан болохлоор бодлого нь Сангийн яаман дээр зохицуулалт, хэрэгжилт, хяналт нь Зохицуулах хороон дээр байдаг. Тэгээд энэ 2 байгууллагын дунд хаягдчихдаг ийм салбар бол ялт ч үгүй даатгалын салбар байдаг. Тэгээд үр дүнд нь даатгалын салбар нь тэлж өгдөггүй, хөгжиж өгдөггүй ингээд мах шиг ингээд борцлогдоод байдаг.

Тэгээд яах вэ энэ салбарт ажиллаж байсан хүн ингээд юм ярихлаар та ингээд чимээгүй байгаач, ашиг сонирхлын зөрчилтэй гэсэн юм яриад байдаг юм л даа. Тэгэхдээ энэ хууль биш болохлоор би бас энэ энэ салбарт бас ажиллаж байсны хувьд бас яг энэ чиглэлээр юун дээр анхаарах ёстой гэдэг дээр хэдэн зүйл хэлчихмээр байгаа юм.

Нэгдүгээрт нь юу байна гээд тэгэхлээр даатгалын зах зээл чинь хөөрхий хүмүүс ингээд том бизнес гэж бодоод байдаг. Гэтэл 300-хан тэрбум байна шүү дээ. Бүгдээрээ дүгнэлтээ хийх хэрэгтэй 300 тэрбум. 300 тэрбум төгрөг энгийнээр харьцуулаад үзэх юм бол автомашин угаадаг тэр салбар чинь 800 тэрбум байгаа юм. Автомашиныг 1 машиныг 35 мянган төгрөгөөр дунджаар угаадаг бол 1 машиныг жилдээ нэгхэн удаа даатгахад 33 мянган төгрөг байгаа байхгүй юу. Яаж тэлэх юм жишээ нь. Жишээ шүү. Хэзээ энийгээ хийсэн юм бэ гээд тэгэхлээр 2011, 2012 онд хийсэн. Тэрнээс чинь хойш инфляц ханиш юу болоод байгаа билээ. Өөрчлөгдөөгүй, хязгаар тавьчихдаг.

Тэгээд үр дүнд нь юу болж байна гээд тэгэхлээр жишээ нь та сайн жолооч байна уу, муу жолооч байна уу үл хамаараад сайн машинтай байна уу, муу машинтай байна уу үл хамаараад бүгдийг нь нэг тэгшитгээд хаячихсан. Тэгээд хүмүүс өөрсдийнхөө эрсдэлийг болохлоор 5 тэрбум төгрөг дээр хязгаарлачихдаг. Өөрөөр хэлэх юм бол 33 мянган төгрөг төлөөд 5 сая төгрөг

ингээж хохирлын нөхөн төлбөр буцааж авдаг.

Гэтэл илүү нөхөр илүү хохирол учирсан тохиолдолд тэрийгээ авах боломжгүй буюу яг энэ даатгалын зах зээлийг бид нар ингээд төр ингээд хатуу ингээд барьчхаад байгаа болохлоор энэ салбар маань хөгжихгүй байна, нэг.

Одоо бас энэ ингээд Зохицуулах хорооноос танилцуулга гарч ирж байна л даа. Даатгалын хураамж нь тухайлбал жолооч чинь хариуцлагын даатгал дээр 13.7 хувь мөртөө даатгалын нөхөн төлбөр нь 34.4 хувь, нийт нөхөн төлбөрийн эзэмших эзлэх хувь нь л даа. Мааш өндөр. Авто тээврийн хэрэгслийн даатгал нь 22.3 хувь хураамжийн орлого нь мөртөө нөгөө нөхөн төлбөр дээр 28.8 хувь байна гээд. Тэгээд л олж ирж байгаа орлогоосоо илүү их өндөр төлбөр төлөөд байхлаар чинь энэ салбар луу чинь хэн бизнес хийх юм.

Тийм болохоор даатгалын компаниуд чинь орж ирэхгүй байгаа шүү дээ. Орж ирсэн тохиолдолд бас гарч чаддаггүй. Яагаад гэвэл зах зээл нь ийм жижигхэн болохлоор хуулиар ингээд хаагаад өгчихсөн жам ёсоор нь ингээд явуулахгүй байгаа болохлоор энэ дээр чинь алдаа байна. Ийм болохлоор одоо энэ Даатгалын хууль дээр чинь та нар яг энэ зах зээлээ өргөжүүлэн хөгжүүлэх байдлаар бодлогын яг арга хэмжээ яг юу гэж тусаж байгаа юм. Энэ дээр тодорхой хариулт авчихмаар байна. Сая энэ Баярсайхан дарга хэлж байна шүү дээ. Олон улсад 60, 40 гэдэг харьцаатай байдаг бол Монголд 99, 1 гэдэг харьцаатай байна гээд. Үнэн шүү дээ. Жишээ нь 0.8 хувьтай л байна шүү дээ. Санхүүгийн зах зээл дотроо. Улам бүүр ингээд хаягдаад гээгдээд байдаг.

Гэтэл хөгжиж байгаа эдийн засагт хамгийн их хэрэгтэй ийм зохицуулалт салбар байгаад байдаг, эрсдэлүүд их бий болоод байдаг. Тэрийг чинь төр биш, хувийн сектор энэ эрсдэлийг нь үүрээд явдаг энэ механизмыг нь та нар яг хэзээ

ажиллуулах юм бэ гэдэг ийм асуудал, асуулт байна.

Хоёр дахь асуулт нь юу байна гээд тэгэхлээр энэ даатгалын үнэлгээ гэдэг юм байна. Өөрөөр хэлэх юм ингээд.../минут дуусав./

**Д.Батлут:** Доржханд гишүүнд 1 минут өгье.

**Т.Доржханд:** Одоо ингээд КОВИД-гүй үед тухайлбал машинууд ингээд гагцхилаа жишээ нь. Тэгсэн тохиолдолд эрсдэл гарахгүй байна. Тэрийг нь хөндлөнгийн үнэлгээний байгууллага үзээд хураамжийнх нь орлогыг буулгадаг, иргэдэд тэр дарамтыг нь буулгадаг. Нөгөө талдаа инфляц өсчихлөө, эдийн засаг сэргээд ирлээ тэгээд тэр үед нь тэр тохируулгыг нь хийдэг price adjustment буюу үнэлгээ хийдэг ийм платформ хэрэгтэй байгаа юм. Энэ юм байна уу. Тендер дээр тухайлбал Оросын компани үнэ өслөө гээд тендерийн тохируулга гээд хийдэг юм шүү дээ олон улсад үнэлгээгээрээ үндэслээд. Ийм платформыг оруулж ирж байна уу, үгүй юу.

Гуравдугаарт нөгөө төр даатгал хийх гээд байдаг гээд л өмнө нь маргаан үүсэж байсан. Одоо албан журмын даатгалын холбоо чинь байна уу, байхгүй байна уу. Ахиж оруулж ирэх гээд байна уу. Тэр 10, 20 тэрбум төгрөгийн эх үүсвэр байсан. Тэр хаана явж байна, тэр мөнгө хаана явна. Тэр дээр л үндэслээд л төр өөрөө л энийг хийнэ гэдэг л ийм хөгийн схемийг өвгөн хийгээд байсан шүү дээ. Тэр дээр та нар ард талд нь цуг байгаад байна уу үгүй байна уу тэр.../минут дуусав./

**Д.Батлут:** Хэн хариулах вэ. Ажлын хэсгийн 4 номерын микрофон нээе.

**Т.Жамбаажамц:** Доржхандын гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга Жамбаажамц байна.

Нэгдүгээрт нь энэ хуульд, Даатгалын тухай багц хууль гэж нэрлээд байгаа энэ Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль гэсэн ийм 3 томоохон хууль бий. Энэ хуулийн өөрчлөлтүүд дээр яг энэ зах зээлийг хөгжүүлэх тэлэх чиглэл дээр ямар өөрчлөлтүүд орж байгаа вэ гэж асуусан.

Жолоочийн даатгалын хууль 11 оны хууль. Үлдсэн тэр 2 Даатгалын хууль, Мэргэжлийн оролцогчийн хууль 2003 оны хууль байж байгаа. Өөрөөр хэлбэл 20 жил энэ салбар дээр үйлчилж байгаа ийм хууль. Тэгээд түрүүн бас хороон дарга хэлсэн томоохон зарчмын өөрчлөлтүүд оруулахаар, оруулаад салбарын хэлэлцүүлгүүд хийгээд өргөн барихаар ажиглаж байна. Доржханд гишүүний яг асуултад тухайлбал тэр жолоочийн даатгалын хууль дээр.../минут дуусав./

**Д.Батлут:** 4 номерын микрофон. Ажлын хэсгийн, тийм.

**Т.Жамбаажамц:** Хураамжийн хэмжээг хуулиар тогтоочихсон байдаг 2011 оны хуулиар. Тэгэхээр шинэ тухайлбал энэ Жолоочийн хариуцлагын шинэчилсэн найруулгын хуулийн төслөөр хураамжийн хэмжээг зохицуулах байгууллага тогтоохоор тусгачихсан байж байгаа. Өөрөөр хэлбэл 33 мянга гэсэн ийм хатуу хуулиар тогтоосон хувь хэмжээ байхгүй, хуулиар тогтоосон хатуу хэмжээтэй байсан учраас өөрчлөх ийм боломжгүй. Зохицуулах байгууллага хороо бол итгэлцүүр тогтоох хэлбэрээр олон дахин давтан зөрчил гаргасан тохиолдол үүсгэсэн жолоочийг арай нэмэгдүүлэх тийм итгэлцүүрээр тохируулга хийж явсан. Одоо бол хуулийн төслөөр инфляцын хэмжээ, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад санхүүгийн зохицуулах байгууллага холбогдох байгууллагуудын саналыг үндэслээд тогтоохоор тухайлбал ингээд өөрчлөлт хуулийн төсөл дээр боловсруулчихсан явж байгаа.

Хуулийн төсөл өргөн баригдаагүй байгаа учраас бол боловсруулалтын шатандаа байгаа мэдээллүүдийг л танд тухайлбал, Хоёрдугаарт нь түрүүний бас мэдээлэл дээр дурдагдаад байгаа. Жилдээ даатгалын салбар дээр хураамжийн орлого 300 орчим тэрбум төгрөгийн хураамжийн даатгалын хураамжийн орлого олж байгаа. Тэрний 100 орчим тэрбум буюу 1/3-ийг нь давхар даатгалын төлбөрт гадагшаа ингээд төлдөг.

Тэгэхээр энэ шинэ хуулийн бас тодорхой зохицуулалт нь давхар үндэсний давхар даатгалын тогтолцоог бэхжүүлэхэд бас нэлээдгүй зорьсон гэх юм уу даа ийм хуулийн өөрчлөлт орж байгаа юм. Ялангуяа дотоодын энэ томоохон даатгалуудын давхар даатгалыг 10-аас доошгүй хувийг нь үндэсний давхар даатгалын компанид даатгуулах ийм эрх зүйн зохицуулалтыг, саналуудыг оруулж ирж байгаа.

Мэдээж даатгалын салбар бол сүүлийн Доржханд гишүүн тэр дата мэдээллүүдээр харсан байх. Борлуулалтын нийт 22 оны даатгалын зах зээлийн борлуулалтын орлогыг 62 хувь орчим хувийг даатгалын компани өөрөө борлуулсан байгаа. Өнгөрсөн жилүүдэд даатгалын төлөөлөгч, зуучлагчаар нийт салбарын бүтээгдэхүүний борлуулалт 50 орчим хувиар явдаг байсан. Тэгэхээр энэ өнгөрсөн, ялангуяа энэ КОВИД-ын жилүүдээс энэ цахим даатгал буюу цахимаар бүтээгдэхүүнийг нь борлуулдаг даатгалын компани өөрөө энэ шилжилтүүдийн процесс дээр нэлээдгүй томоохон ийм ахиц гарч байгаа.

Тэгэхээр бид нар энэ цахимаар хэрхэн яаж даатгалын бүтээгдэхүүнээ хийх вэ, борлуулах вэ, гэрээ контрактыг хэрхэн байгуулах вэ гээд энэ зохицуулалтынх нь хувилбаруудыг, зохицуулалтыг нь оруулж ирж байгаа.

Нөгөө талаасаа энэ албан журмын даатгалын тогтолцоо Монголд 18 хууль тогтоомжоор албан журмын буюу заавал даатгалын төрлүүдийг тодорхойлсон байж байгаа. Үүнд бол эмчийн гэдэг юм уу, хуульчийн гэдэг юм уу, нотариатчийн, өмгөөлөгчийн, барилгын, газар тариалангийн гээд өөрөөр хэлбэл орчин тойрондоо эрсдэлтэй үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн хариуцлагуудыг заавал даатгадаг.

Тэгээд салбар салбар нь өөрөө даатгаад явдаг боловч нэгдсэн ийм зохион байгуулалт байхгүй, 1 салбарыг бүхэлд нь даатгалын компанид тухайлбал даатгуулдаг ийм эрсдэлүүд байсан. Тэгэхээр энийг шинэ хуулиар дундын нэгдсэн зохицуулалттай болгоод тэгээд үүгээрээ дамжуулаад тухайн салбарынх нь төрийн захиргааны төв байгууллага, санхүүгийн зохицуулах байгууллага, Сангийн яам хамтраад энэ хэрэгжилтийнх нь асуудлыг илүү тодорхой болгож ялангуяа тэр хураамж, активар тооцоолол зэрэг дээр энэ мэргэжлийн байгууллагууд нэгдсэн ийм зохион байгуулалтаар хангах ийм бас хуулийн томоохон юу гэдэг юм өөрчлөлтүүдийг хийхээр төлөвлөж байгаа.

Тэгээд дараагийн дугаарт нь энэ даатгалын бүтээгдэхүүний төрлүүдийг нэмэхээр, төрлүүдийг нэмэх зэрэг ийм нэлээдгүй олон хуулиудын зохицуулалтуудыг оруулж байгаа.

Эцэст нь таны бас 2 дахь асуулт тэр үнэлгээтэй холбоотой асуулт байгаа. Даатгалын хохирлын үнэлгээтэй. Өнөөдрийн хуулиар даатгалын хохирлын үнэлгээний компаниуд тусгай зөвшөөрөлтэй компаниудаар хохирлын үнэлгээ гардаг.

**Д.Батлут:** Гүйцээж хариулъя. 4 номерын микрофоныг нээе.

**Т.Жамбаажамц:** Хохирлын үнэлгээний компанийг даатгалын



компанийн томилсон хохирлын үнэлгээний компаниар хохирлын үнэлгээ гаргаад тэгээд тэр хохирлын үнэлгээг үнэлгээнд үндэслэж даатгалын нөхөн төлбөр олгох процесс явагддаг. Үүнийг бол шинэ хуулиар энэ даатгалын компани өөрөө бас тодорхой тэр хохирлын үнэлгээг гаргадаг, өөрөө тэр хохирлын үнэлгээний мэргэжилтэнтэй байх, шаардлагатай бол тэн дээр нь маргаан юмнууд үүсдэг бол гуравдагч тийм хохирлын үнэлгээний компаниар хийлгүүлдэг.

Өөрөөр хэлбэл иргэдэд маш хурдан шуурхай даатгалын нөхөн төлбөр олгох энэ зохицуулалтуудыг оруулж ирж байгаа. Тэгээд мөн энэ тухайлбал хугацаан дээр аягүй их гомдол гардаг. Өөрөөр хэлбэл ажлын 10 хоног, хохирлын үнэлгээ гарснаас биш ажлын 10 хоногийн дотор, ажлын 30 хоногийн дотор даатгалын нөхөн төлбөрийг олгоно гэдэг ийм зохицуулалттай байсан бол хохирлын үнэлгээг хүлээлгүйгээр тухайлбал албан журмын даатгалыг яаралтай нэн даруй барагдуулж төлбөрийг, хохирлын нөхөн төлбөрийг олгохоор тухайлбал ийм ийм хуулийн нэлээн өөрчлөлтүүд бид нар Сангийн яамтай хамтраад боловсруулчихсан байж байгаа. Тэгээд энэ хуулийг өргөн баригдах үед илүү дэлгэрэнгүй нарийн зүйлүүд яригдах байх. Баярлалаа.

**Д.Батлут:** Доржханд гишүүн тодруулъя. 1 минут.

**Т.Доржханд:** Миний нөгөө асуултад бас тодорхой хариулаарай. Аялал жуулчлал, албан журмын даатгалын сан гээд 10-20 тэрбум төгрөг байсан. Тэр мөнгө хаана явна вэ гэдэг дээр. Нэг.

Хоёрдугаарт цаашид энэ сан байх юм уу. Тэгээд санг хэн удирдаж явах билээ. Энэ дээр хариулчихмаар байна. Тэгээд нөгөө заавал даатгал олон улсад байдаг, өгч байгаа оронд байлгүй яах вэ. Гэхдээ энийг заавал төр хийх албагүй шүү дээ нөхдүүд ээ. Энийг чинь хувийн

компаниуд хийгээд явах учиртай. Яг энэ зарчмаараа хуулийнхаа төсөлд орж байна уу, үгүй байна уу. Тийм, энэ дээр тодорхой хариулт авчихмаар байх юм.

Тэгээд цаашаагаа энэ тэлэлтээ та нар ер нь яг яаж төсөөлж байгаа юм. 1 хувь хүрэхгүй байна шүү дээ. Хэдэн хувь гэж төсөөлж байгаа юм. Ямар арга замаар гэдэг төсөөлөл байна уу. Энэ дээр та бүгд өөрсдийнхөө ажил хариуцаж байгаа хүний хувьд Зохицуулах хорооноос нэмэх нь бас бодлого барьж байгаа гэдгээрээ Сангийн яамнаас бас энэ төсөөллөө өгчихмөөр байх юм. Энэ салбар ер нь хөгжих юм уу, хөгжихгүй юм уу. Эсвэл нүдийг нь аниулаад ингээд хая.../минут дуусав./

**Д.Батлут:** Доржханд гишүүн тодорхой асуулт асуусан. 4 асуулт байна. Маш тодорхой хариулж өгөөрэй. 2 номер номерын микрофоныг нээе.

**Н.Хүдэрчулуун:** Сайн байна уу. Доржханд гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулан хорооны дэд дарга Хүдэрчулуун. Гишүүн маш чухал асуудал хөндөж байна. Даатгалын салбар бол санхүүгийн салбарын нэг гол тулгуур багана байх ёстой. Өөрөөр хэлбэл нийт дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээгээрээ бас нийгэм эдийн засагт нөлөө үзүүлэх маш том салбар. Монгол Улсын хувьд түрүүний дурдагдсан статистик үзүүлэлтээс харахад 10 дахин бага ийм жижиг байгаа гэдэг нь үнэн.

Тэгэхээр бид Санхүүгийн зохицуулах хороо Сангийн яамтай хамтраад энэ хууль, эрх зүйн шинэтгэлийг хийхээр ингээд ажиллаж байна. Яг энэ хууль, эрх зүйн шинэтгэлийг хийснээр бас энэ бид нарын төсөөлж байгаагаар даатгалын салбарыг илүү нийгэм, эдийн засагт нөлөө үзүүлэхүйц ийм том салбар болгож хөгжүүлнэ гэсэн ийм бодлогыг барьж байгаа юм. Өөрөөр хэлбэл 10 дахин бага байна гэдэг маань Монгол Улсын энэ санхүүгийн зах зээл дээр тэдний хэмжээний энэ зах зээл бол ер

*нь байх боломж байгаа.../минут дуусав./*

**Д.Батлут:** Хариултыг гүйцээе. Тодорхой асуулт бол тодорхой байгаа шүү дээ. Тэгээд л тодорхой л хариулт өгчих за юу. Нуришиж хэрэггүй.

**Н.Хүдэрчулуун:** Тэгэхээр энэ хуулийн энэ төслийн гол өөрчлөлт дээр орж байгаа нэг гол юм нь бол даатгалын салбарын тэр бүтцийг эрүүл, зөв болгох гээд. Түрүүн гишүүн бас хэллээ 99, 1 гэсэн хувь харьцаатай байж байгаа. Өөрөөр хэлбэл энэ урт хугацааны буюу амьдралын даатгалыг илүү даатгалын салбарт бас жин дарах ийм бүтцийг сайн зөв болгох, эрүүл болгох ийм чиглэлийн ажлууд хийж байна. Тухайлбал Санхүүгийн зохицуулах хороо энэ ипотекийн даатгалыг илүү амьдралын даатгалд шилжүүлэх энэ ажлыг бас энэ банк болон технологид суурилсан энэ пентек компаниудтай хамтарсан энэ insure-тэй компаниудтай хамтраад бас энэ тогтолцоог бий болгохоор ингээд ажиллаж байна. Одоо ерөнхий журмын төсөл бол бэлэн болсон. Банкны хувьд бол даатгалын салбарын бас нэг гол борлуулагч байдаг.

Тэгэхээр энэ шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд туссанаар бол банкнууд яг олон улсын жишигээрээ банк insurance гэдэг энэ салбараараа хөгжих ийм зохицуулалт бас орж байгаа. Нөгөө талаасаа тэр заавал даатгалын нэр төрлийг олируулах энэ ажлууд бас.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гүйцээж хариулъя. 2 номерын микрофон.

**Н.Хүдэрчулуун:** Тэгэхээр тухайн яг салбарын эрсдэлийг бүтэн зургаар нь, тогтолцоогоор нь гаргаж яг салбартай нь хамтарч ажиллахаар Санхүүгийн зохицуулах хорооноос ажлын хэсэг байгуулаад ажиллаж байна. Тухайлбал Эрүүл мэндийн яам, Байгаль орчны яамнууд дээр яг энэ заавал даатгалын тогтолцоо нь ямар байх ёстой вэ гэдэг

энэ тогтолцоог нь хууль, эрх зүйн хувьд ямар зохицуулалтуудыг ямар хамтарсан журмуудыг боловсруулах шаардлагатай вэ тийм хувийн секторууд маань энд оролцож ажиллах ёстой тийм. Төр бол оролцохгүй.

Албан журмын даатгалын холбооны хувьд бол сая өнгөрсөн хоёр долоо хоногийн өмнө гүйцэтгэх захирлыг 5 сарын 20-доор гүйцэтгэх захирлыг чөлөөлсөн байгаа. Ингээд нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж, шинээр гүйцэтгэх удирдлагыг өнгөрсөн долоо хоногт шинээр томилоод ажиллаж байгаа. Тэр сангуудын хувьд үндэсний хөрөнгө оруулалтын болон Чингис хаан банкин дээр бас найдваргүй авлагууд үүссэн байдаг. Энийг шүүхэд бас гомдол гаргачихсан шүүхээр бас асуудлууд шийдэгдэхээр ингээд явж байгаа. Ойролцоогоор 6 орчим тэрбум төгрөгийн ийм энэ хоёр банкин дээр дийлэнх нь Чингис хаан банкин дээр, Үндэсний хөрөнгө оруулалтын банк дээр нь 400 орчим, 500 орчим сая төгрөгийн ийм, нийт 27 тэрбум төгрөгийн сан байгаа. Эндээс Авто тээврийн үндэсний зөвлөлөөс, Ерөнхий сайдын Үндэсний зөвлөлөөс бас тодорхой санхүүжилтийг хийх ийм чиглэл өгөгдсөн байж байгаа. Зам, тээврийн яамны сайд болон Сүхбаатар сайд нарын хамтарсан ийм зам тээврийн ослыг бууруулах болон энэ авто түгжрэлийг бууруулах ийм үндэсний том системийг хийж байгаа. Энэ системд энэ албан журмын даатгалын энэ системүүд холбогдох ёстой.

Ингэснээр бас энэ албан журмын даатгалын энэ зөвхөн динамик байдлаар энэ эрсдэлийг үнэлдэг байсан бол бид нар илүү big data дээр суурилсан, илүү статик мэдээлэл дээр суурилсан хүний, хувь хүнд тохирсон эрсдэлүүдийг яг бодитойгоор тооцоолох боломж бүрдэнэ гэж харж байгаа. Яг энэ зориулалтын дагуу мэдээллийн энэ санг Албан журмын даатгалын сантай холбох, бусад дэд бүтцийн асуудлуудыг шийдэх зорилгоор 10 тэрбумыг энэ сангаас энэ Зам,

тээврийн яаманд шилжүүлсэн байгаа. Одоо үлдсэн мөнгөнүүд нь бол энэ 10 гаруй тэрбум нь бол бусад арилжааны банкнууд дээр байршдаг.

Цаашидаа бол илүү энэ сангийн нөөц хөрөнгүүд бол хөрөнгийн зах зээл дээр бас тодорхой илүү өгөөжтэй байдлаар хөрөнгийн менежментийг илүү сайжруулах чиглэлээр ажиллах үүрэг даалгавруудыг Удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захирал, ажлын албанд даалгачихсан ингээд ажиллаж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Даатгалын салбарын эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдлын талаарх холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсож дууслаа.

Ингээд Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хурал өндөрлөснөө мэдэгдье. Хуралд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

13.09 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР